

«ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» СЭТГҮҮЛЭЭ ЗАХИАЛААРЫН

«Төрийн мэдээлэл» сэтгүүлд Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа хууль тогтоомжууд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг захирамжууд, Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр, Засгийн газрын чухал тогтоолууд болон Монгол Улсын хуулиудын талаарх Улсын Дээд Шүүхийн тайлбарууд бүрэн эхээрээ хамгийн түргэн шуурхай нийтлэгддэг билээ.

«Төрийн мэдээлэл» сэтгүүл нь улсын үйлдвэр аж ахуйн газар, хууль хяналт, санхүүгийн байгууллага, нөхөрлөл, улсын болоод хувийн компани, хоршооны удирдах хүмүүс, болон ХЭАА, санхүү-эдийн засгийн ажилтнуудын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулагдсан ширээний ном юм.

Сэтгүүлийн нэг бүрийн үнэ 500 төгрөг бөгөөд IV улирлын захиалгын нийт 1500 төгрөг бөгөөд мөнгөө Улаанбаатар хотод «Монгол шуудан» компанийн монгол шуудан банкин дахь 2102002 тоот дансанд, бусад аймаг хот, сум суурин газруудад тус тусын банкны салбар дахь тухайн аймгийн шуудан холбооны албаны хэвлэлийн харилцах дансанд тушааж тооцоо хийнэ.

Таны найдвартай туслагч, хууль зүйн үнэнч зөвлөгч «ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» сэтгүүлээ өргөнөөр захиалан уншигсаана уу

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1996 оны 8-р сар

№8 /51/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төмөр замын тээврийн амуулгүй байдлын тухай	425
Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	441
Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай	441
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай	442
Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	454
Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	454
Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай	455
Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	456
Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	457
Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	457
Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	458

II. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай №01	459
Санал хураах комисс байгуулах тухай №02	461
Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай №03	462
Санал хураах комисс байгуулах тухай № 04	462
Монгол Улсын Ерөнхий сайдыг томилж тухай №05	463
Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай № 07	464
Байнгын хорооны даргыг сонгох тухай №08	464

19.	Н. Багабандийн хамгаалалт хангамжийн тухай №09	465
20.	П. Жасрайгийн хамгаалалт, хангамжийн тухай № 10	465
21.	Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай № 11	466
22.	Улсын Их Хурлын Байнгын хороодын даргыг сонгох тухай № 12	471
23.	Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай № 13	471
24.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 14	472
25.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 15	472
26.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 16	472
27.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 17	472
28.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 18	472
	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 19	472
30.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 20	472
31.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай № 21	472
32.	Зарим хүмүүсийг ажлаас чөлөөлөх тухай № 22	

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

33.	Д.Пүрэвдоржид Монгол Улсын ардын зохиолч цол олгох тухай № 135	47
34.	Б.Зангадад Монгол Улсын ардын жүжигчин цол олгох тухай № 138	47
35.	Г.Баасансүрэнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгох тухай № 137	47
36.	Б.Базарт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол олгох тухай № 138	47
37.	Ц.Бат-Очирт Монгол Улсын гавьяат холбоочин цол олгох тухай № 139	47
38.	М.Могойтарт Монгол Улсын гавьяат барилгачин цол олгох тухай № 140	47
39.	Н. Баасанжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай № 141	48
40.	Н. Нинжээд хүний гавьяат цол олгох тухай № 142	48

4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

41. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай № 01 481

5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

42. Нийгмийн халамжийн үндэсний зөвлөл байгуулах тухай № 41 485
43. Санхүүгийн улсын хяналт шалгалтын дүрэм батлах тухай № 46 488
44. Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх талаар авах арга хэмжээний тухай № 47 494

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэсэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдож төмөр замын болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын
тухай хууль тогтоомж

1. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зэвсгээс өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар айлгано:

1/ "төмөр замын тээврийн байгууллага" /дараахь "төмөр замын байгууллага" гэх/ гэдэгт өмчлөгчөөс эрх олгосноор төмөр замын эбъектыг эзэмшиж, ашиглаж, төмөр замын тээврийн үйл ажиллагааг голлорсон нэгдмэл удирдлагаар ханган, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төмөр замын бусад байгууллагатай үйл ажиллагаагаа харилцан ялдуулж, улсын болон бус нутгийн эдийн засаг, хүн амд төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий хуулийн этгээдийг;

2/ "тээвэрлэлтийн үйл ажиллагаа" гэдэгт ачаа, тээврийг тээвэрлэхэд бэлтгэх, хүлээн авах, ачих, тээвэрлэх, буулгах, хүлээн авагчид үлээлгэн өгөх болон зорчигч тээвэрлэх үеийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаатай цогцолбор ажил, үйлчилгээг;

3/ "зорчигч" гэдэгт зорчигчийн галт тэргээр зорчин явах асалбартайгаар аялж яваа этгээдийг;

4/"ачаа" гэдэгт тогтоосон журмын дагуу ачланы вагоноор тээвэрлэхээр хүлээн авсан эд зүйлсийг;

5/"тээш" гэдэгт тогтоосон журмын дагуу зорчигчийн галт тэргээр тээвэрлэж байгаа эд зүйлсийг;

6/"төмөр замын байгууламж" гэдэгт төмөр замын холбоо, дохиолол, эрчим хүч, усан хангамжийн сүлжээний тоног төхөөрөмж, ул шороо, зам шугам, гарам, гүүр, хоолой, хориг хашаа, үерийн хамгаалалтыг;

7/"төмөр замын объект" гэдэгт төмөр замын байгууламж, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, техник болон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйлдвэр-технологийн барилтыг;

8/"төмөр замын шугам" гэдэгт төмөр замын өртөө хоорондын шугам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг;

9/"салбар зам" гэдэгт сэлгээний болон ачих, буулгах ажил хийх зориулалтаар төмөр замын шугам, өртөөний замаас салаалж тавьсан зам шугамыг;

10/"төмөр замын гарам" гэдэгт авто зам, төмөр замын шугамтай нэг түвшинд огтлолцсон уулзварыг;

11/"овор" гэдэгт хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүйн техникийн шаардлагын дагуу төмөр замын объект, хөдлөх бүрэлдэхүүн, төмөр замын ойролцоох барилга байгууламж, ачаа байршлын зайн хязгаарыг тогтоосон хэмжээг;

12/"төмөр замын зурвас газар" гэдэгт төмөр замын байгууламж байрлаж байгаа, төмөр замын шугамын дагуух тээврийн аюулгүй байдлыг хангах, технологийн онцлог үйл ажиллагааг явуулах зориулалт бүхий газрыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн аюулгүй байдал

4 дүгээр зүйл Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах

1.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах явдал нь зорчигчийн осол аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээгчийг бүрэн бүтэн тээвэрлэх, тээврийн болон техник хэрэгслийг аюулгүй ашиглах, төмөр замын ажилтанд таних аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад чиглэсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаагаар хэрэгжинэ.

2.Төмөр замын тээврийг зохион байгуулах, аюулгүй байдлыг нь хангах журам, төмөр замын объектын техникийн болон ашиглалтын нөхцөл, тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтны эрх,

үүрэг, харнуцлагыг төмөр замын техник ашиглалтын дүрмээр зохицуулна.

5 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын зарчим

Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төмөр замын байгууллага, ажилтан үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

- 1/төвлөрсөн нэгдмэл удирдлагатай байх;
- 2/тээврийн үйл ажиллагаа тасралтгүй байх;
- 3/байнгын хяналттай байх.

6 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, онцгой нөхцөл дэх ажлын зохион байгуулалт

1. Төмөр замын байгууллага, түүний салбар, нэгж болон салбар зам эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжийн галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг технологийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн график /шашид "зурмаг" гэх/-аар зохицуулна. Зурмагийг төмөр замын байгууллагын дарга батална.

2. Галт тэрэгний хөдөлгөөнийг түүний захирагчийн, сэлгээний хөдөлгөөнийг өргөөний жижүүрийн удирдлага, хяналтын дор, зурмагийн дагуу гүйцэтгэнэ.

3. Төмөр замын шугам болон өргөөний замд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг төмөр замын байгууллагын даргын тогтоосон хурдаар явуулна.

4. Төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой ажлыг зогсоохыг хориглоно.

5. Эрчим хүчээр хангагч нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын технологийн тасралтгүй ажиллагааг хангах үүднээс төмөр замын байгууллагад эрчим хүчний хангалтыг хязгаарлахгүй байх үүрэгтэй.

6. Зорчигч, тээш тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн галт тэргийг өргөө, зорлогт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч, явуулна. Зорчигчийн галт тэргийг хүлээн авах, явуулах зориулалтын зам нь тогтоосон хэмжээний гэрэлтүүлэг, тавцан, талбайтай байна.

7. Төмөр замын байгууллага салбар зам эзэмшигч, ашиглагч нь тэмдэг, дугаар бүхий "хатуу тооцоотой" багаж хэрэгсэлтэй байна. Хатуу тооцоотой багаж хэрэгслийн жагсаалт, тоо, хүлээлцэх журмыг төмөр замын байгууллага тогтооно. Багаж, хэрэгслийн жагсаалтыг улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

8. Цацраг идэвхит болон химийн бодисын хордуулалт, хун, малын тос халдварт өвчний улмаас хорно цээр тогтоосон тухай холбогдох

байгууллагын шийдвэрийг үндэслэн төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр тухайн бүс нутагт төмөр замын тээврийн үйл ажиллагааг уг нөхцөл байдал арилтал зогсоож болох бөгөөд энэ тухай байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд зарлаж мэдээлнэ.

9.Төмөр замын байгууллага гал түймэр, осол, сүйрэл, байгалийн гамшигийн хор уршгийг арилгах зориулалтын техник хэрэгсэл бүхий сэргээн босгох болон галын галт тэрэгтэй байх, тэлгээрийг байнгын бэлэн байдалд байлгах үүрэгтэй. Сэргээн босгох болон галын галт тэргийг байрдуулах газрыг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

10.Төмөр замаар тээвэртэх нууц болон хүн ам, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхит, хортой бодисыг ачиж буулгах, тээвэртэх, хадгалах журмыг төмөр замын байгууллага улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

11.Монгол Улсын төрийн тэргүүн, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг өндөр албан тушаалын хүн зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн батална.

12.Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангхтай холбоотой технологийн горимыг төмөр замын байгууллагын даргын баталсан техник ашиглалтын дүрэм, дохиолол, холбооны болон галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөний журмаар тогтооно.

7 дугаар зүйл.Төмөр замын объект ашиглахад
тавих шаардлага

1.Төмөр замын дагуу барих буюу ашиглаж байгаа барилга, байгууламж төмөр замын тээврийн хэвийн ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага, улсын болон төмөр замын байгууллагын стандартын шаардлагыг хангасан байна.

2.Хэтрүү овортой болон аюултай ачааг зөвхөн төмөр замын байгууллагын даргын олгосон зөвшөөрлөөр, тогтоосон журмын дагуу тээвэрлэнэ.

3.Зохих журмын дагуу шалгаж, баталгаажуулаагүй төмөр замын объектыг төмөр замын тээвэрт ашиглахыг хориглоно.

4.Төмөр замын байгууламжийг нурамтгай, гулгамтгай хөрс, үср усны аюулаас хамгаалж сэргийлэхийн тулд хамгаалалтын байгууламж барина.

5.Төмөр замын шугамын тодорхой хэсгийг өргөтгөх, татан буулгах бол энэ тухай төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

8 дугаар зүйл. Төмөр замын гармыг ашиглах дэглэм

1. Төмөр замын гармыг нээх, хяах, хамгаалалтын дохио, тэмдэг, төхөөрөмжөөр тоноглох, засварлах, түүний зэрэглэлийг тогтоох журмыг төмөр замын байгууллага цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батална. Төмөр замын гармын байршил, тогтоохдоо нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзана.

2. Гиджит машин механизм, хэтрүү овортой ачаа бүхий авто тээврийн хэрэгслийг төмөр замын гармаар гаргахдаа төмөр замд тухайн гармыг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтныг зөвшөөрлөөр, түүний томилсон ажилтны хяналтын дор гүйцэтгэнэ.

9 дүгээр зүйл. Салбар зам эзэмших, ашиглах дэглэм

1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн салбар зам барих, түүнд өргөтгөл хийх, татан буулгахдаа тухайн салбар замыг үйлчлэх төмөр замын байгууллагаас зөвшөөрөл авна.

2. Салбар зам эзэмших, ашиглахад төмөр замын байгууллага, салбар зам эзэмшиж, ашиглаж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хооронд байгуулсан гэрээг мөрдөнө.

3. Салбар зам эзэмшиж, ашиглаж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэн салбар замд салгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, салбар зам дээрх төмөр замын объектыг тогтоосон журмын дагуу ашиглах, үхэлт оруулах, тээврийн аюулгүй байдлын талаар төмөр замын байгууллагын нэгдсэн удирдлагад захирагдах, ажлын технологийн горимыг мөрдөх, салбар зам ашиглах гэрээг данлар өөрчлөхгүй байх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Төмөр замын дохиолол, холбоо

1. Төмөр замын тээврийн хөдөлгөөний зохицуулалтад дуут болон үзэгдэх дохио хэрэглэнэ. Дуут дохионд зүтгүүр, төмөр замд ачаа тээврийн бусад хөдлөх бүрэлдэхүүний шүтэл, төмөр замын багт, төмөр замын ажилтны гэр шүтэл, бүрээний дуу хамаарна. Үзэгдэх дохионд тогтоосон өнгийн дохионы гэрэл, дарцаг, самбар, тэмдэг хамаарна.

2. Төмөр замын байгууллага нь галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг удирдах, зохицуулахдаа галт тэрэгний хөдөлгөөний захирагчийн, ортоо хоорондын, зам шугамын, сумчны, галт тэрэгний утсан, радио холбоо, төмөр замын гол шугамын утсан болон бусад холбоог хэрэглэнэ.

11 дүгээр зүйл. Төмөр замын зурвас газар, түүний дэглэм

1. Төмөр замын зурвас газар нь ортоо хоорондын замд 120 метр, ортооний хязгаарт 300 метрийн өргөнтэй байна.

2. Төмөр замын зурвас газарт мал бэлчээх, төмөр замд холбогдолгүй ажил гүйцэтгэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

3.Төмөр замын зурвас газарт мод, бут, өсө, ургамал нь тээврийн аюулгүй байдалд саад учруулах нөхцөл бүрдсэн тохиолдолд төмөр замын байгууллага тэдгээрийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох, халгах, түймэр гаргахгүйгээр шатаах зэргээр аюулгүй байдлын нөхцөлийг хангана.

4.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт-буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр нутаг /шаашид "аюултай бүс" гэх/, төмөр замын зурвас газрын шаардлагатай хэсэгт төмөр замын болон, салбар зам эзэмшигч байгууллага хаалт, хамгаалалт хийнэ.

5.Аюултай бүс нь аюулгүй байдлыг хангахуйц гэрэлтүүлэгтэй байна. Өртөө, зөрлөгийн гэрэлтүүлэг, чимэглэл нь зохионы үзэсгэлтийг бууруулахаар байж болохгүй.

6.Төмөр замын аюултай бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, төмөр замын шугамыг хөндлөн гарах нийтлэг үндэслэл, журмыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.Төмөр замын зурвас газар улсын тусгай хэрэгцээний газарт хамаарах бөгөөд төмөр замын байгууллага эзэмшиж, ашиглана.

8.Галт тэрэгний хөдөлгөөн, сэлгээний болон ачилт буулгалтын ажлыг хэвийн явуулах, төмөр зам дээр тохиолдож болох осол, сүйрэлтээс хамгаалах, байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд учрах хор хөнөөлийг багасгах, тэдгээрийн аюулгүй нөхцөлийг хангах зорилго бүхий аюулгүйн бүс нь төмөр замын гол шугамаас хоёр тийш 500 метрийн өргөнтэй байна.

9.Аюултай бодис үйлдвэрлэх, хадгалах, ачих, буулгах объектыг төмөр замын аюулгүйн бүсэд барих, байрлуулахыг хориглоно.

10.Хот тосгоны хилийн зааглас гадна орших аюулгүйн бүсэд төмөр замчлаас бусад байгууллага, аж ахуйн нэгж байрлах, айл суурьшныг хориглоно.

11.Төмөр замын байгууллагаас бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэн аюулгүйн бүсэд аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга төмөр замын байгууллагын даргатай зөвшилцөн олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын талвар
төрийн байгууллагын бүрэн эрх

12 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх
Засгийн газар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1/төмөр замын тээврийн үндсэн дүрэм, төмөр замын тээврийн улсын хяналтын дүрэм, төмөр замын хамгаалалтын албаны дүрэм,

төмөр замын ажилтны сахилгын тусгай дүрмийг батлах;

2/Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төмөр замын шугам барих зөвшөөрөл олгох;

3/төмөр замын зурвас газрыг төмөр замын байгууллагын эзэмшилд тодорхой хугацаа, нөхцөлтэйгээр олгох, газрын төлбөр авах, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

4/төмөр замын байгууллагад нөхөн төлбөр олгосны үндсэн дээр нийгэм, эдийн засагт шууд нөлөөтэй зарим нэр төрлийн ачааны тээвэрлэлийг тогтоосон тарифаас доогуур тарифаар гүйцэтгүүлэх.

13 дугаар зүйл Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төмөр замын тээврийн салбарт төрийн зохицуулалтыг гүйцэтгэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах үндсэн чиг үүрэгтэй байна.

2.Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах;

2/төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх, төмөр замын техник хэрэгсэл үйлдвэрлэх, төмөр замын объект ашиглах зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгох, хүчингүй болгох;

3/төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх, төмөр замын техник хэрэгсэл үйлдвэрлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эзэмшилд олгох газрын зураглал, төслийг хянаж саналал Засгийн газарт оруулах;

4/төмөр замын асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох;

5/төмөр замын тээврийн салбарт Засгийн газраас хийсэн хөрөнгө оруулалт, гүүнчлэн гадаад орны эзэл тусламжийн хөрөнгийн шингэлэлт, зарцуулалтад хяналт тавих.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,4-г заасан бүрэн эрх, болон төмөр замын үйл ажиллагаанд захиргааны хяналт тавих бүрэн эрхийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу төмөр замын аль нэг байгууллагаар хариуцуулан гүйцэтгүүлж болно.

14 дүгээр зүйл Аймаг, нийслэл, сум, дүүргийн

Засаг даргын бүрэн эрх

1.Төмөр зам дайран өнгөрдөг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/төмөр замын холбогдох байгууллагатай харилцан ажиллах;

2/төмөр замын зурвас газар, өртөө, буудал, объектод нийгмийн гэнэ журам сахуулах ажлыг төмөр замын байгууллагатай хамтран

зохион байгуулах;

3/хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төмөр замын ашиг-лалт, зүтгүүр, вагон, зам, дохиолол холбоо, эрчим хүч зэрэгт ээлжээр ажилладаг ажилтныг цэргийн албанд татахас бусад дайчилгаанд хамрааруулахгүй байх;

4/байгалийн гамшиг, осол, сүйрлийн хор уршгийг арилгах, төмөр замын байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах мод, хайрга чулуу, алс, ус зэргийг хууль тогтоомжийн дагуу олгох;

5/төмөр замын осол, сүйрлээс урьтчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай бол нутаг дэвсгэрийнхээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор гаргуулах, хүн хүчнийг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, үүрэг

15 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хууль, гэрээнд зааснаас гадна дор дурдсан эрхийг эдэлнэ:

1/аюулгүй байдлыг хангасан хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгс-лээр үйлчлэхийг шаардах;

2/тээвэртүүлэх ачаанд төхирсөн төрлийн вагоныг сонгон авах;

3/үнэ, тариф, үйлчилгээний хөлс, галт тэрэгний цагсийн хуваарь, ачаа ирэлтийн талаар мэдээлэл авах;

4/төмөр замын байгууллагын үйлчилгээг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэх;

5/36 килограммаас илүүгүй жинтэй гар тээшнийг үнэ төлбөргүй авч явах, хот, дүүргийн галт тэргэнд дээр дурдсанаас гадна 50 кило-граммаас хэтрэхгүй жинтэй тээшнийг тарифын хөлс төлөн авч явах;

6/төмөр замын байгууллага, албан тушаалтан хууль, гэрээнд за-сан үүргээ биелүүлдэггүй буюу хангалтгүй биелүүлсэнтэй холбогдсон гомдлоо тогтоосон журмын дагуу төмөр замын байгууллагад гаргах. Төмөр замын байгууллагын шийдвэрийн талаар гомдлоо шүүхэд гаргана.

16 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг

1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дор дурдсан үүрэгтэй байна:

1/төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан шийдвэр, эрх зүйн бусад актыг биелүүлэх;

2/төмөр замын зурвас газар, аюултай болон аюулгүйн бүс, төмөр замын объектод нэвтрэх, үйл ажиллагаа явуулахдаа төмөр замын байгууллагын дарга буюу энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасан албан тушаалтнаас зөвшөөрөл авах;

3/ажлал үүргээ гүйцэтгэж байгаа төмөр замын ажилтнаас эрх хэмжээнийгхээ хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх;

4/гэрээгээр үйлчлүүлдэг буюу өртөө, зөрлөгийн замыг ашиглаа өөрийн хөдлөх бүрэлдэхүүнээр үйл ажиллагаа явуулах бол тухайн төмөр замын байгууллагын техник ашиглалтын дүрмийг мөрдөх. Энэ заалтад заасан этгээдийн төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан хөдөлгөдөх төмөр замын байгууллагын мэргэжлийн комисст жил тутам шалгалт өгч, ажиллах эрх авна;

5/иргэн, төмөр замын тээврээр зорчих болон төмөр замын аюултай бүсэд байхдаа хэв журмыг чанд сахих, тээврийн хэрэгслийн эд анги, бусад хөрөнгөд гамтай хандах;

6/хүний эрүүл мэнд, амь нас хохирох, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг зорчих үйлдэл, осол, сүйрэл гарах нөхцөл бүрдсэн бол энэ тухай төмөр замын байгууллага, сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх;

7/төмөр замын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, тээврийн хэрэгслийг саатуулснаас учруулсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу нөхөн төлөх;

8/төмөр замын тээвэрлэлтийн явцад хүний амь нас, эрүүл мэнд, ачааны бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулсан осол, сүйрэл гарсан, байгалийн гамшиг тохиолдсон үед төмөр замын байгууллагад мэдэгдэх, туслалцаа үзүүлэх.

2.Төмөр замын тээврийн технологийн зориулалттай шахилгаан эрчим хүч, усан хангамжийн шугам сүлжээнээс төмөр замын байгууллагын зөвшөөрөлгүйгээр холболт хийх, ашиглахыг хориглоно.

3.Тэсэрч дэлбэрэх, түргэн шатах, цацраг идэвхит болон химийн хорт бодис зэрэг аюултай ачааг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ачаа илгээгч, эсхүл хүтээн авагч заавал дагалдах бөгөөд тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын баталгааг хариуцаж, гарч болох ослын хор уршгийг арилгах хүч хэрэгсэлтэй байна. Өндөр үнэтэй, түргэн гэмтэх, муудах ачааг тээврийн гэрээнд заасан тохиолдолд дагалдаж болно.

4.Зорчигчийн болон ачаа-суудлын галт тэргээр аюултай, эвгүй

үнэртэй ачаа, тээш тээвэрлэх, энэ хуулийн 15 дугаар зүйлийн 5-д зааснаас илүү тээш авч явахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын талаар төмөр замын байгууллагын эрх, үүрэг

17 дугаар зүйл. Төмөр замын байгууллага,
түүний эрх, үүрэг

1. Төмөр замын байгууллага нь шууд үйлдвэрлэлийн, цэрэгжүүлсэн хамгаалалтын болон хяналтын албатай байна.

2. Төмөр замын байгууллага нь худалдаа, орон сууц, холбоо, эрүүл мэнд, сургалт, эрдэм шинжилгээ, зураг төслийн зэрэг салбар нэгжтэй байж болно.

3. Төмөр замын байгууллага нь төмөр замын тээвэрлэлт, түүний аюулгүй байдлын талаар дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

1/хэрэглэгчдийн захиалга, төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг харгалзан боловсруулж баталсан төлөвлөгөө, гэрээний дагуу зорчигч, ачаа, тээшийг тээвэрлэх;

2/эээмшиж буй төмөр замын объект, салбар зам, техник хэрэгсэлийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, тэдгээрийн бүртгэлийг хөтөлж, тогтоосон журам, технологийн дагуу үзлэг, үйлчилгээ хийх;

3/төмөр замын тээврийн үнэ, тарифыг улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, хэрэглэгчийн ашиг сонирхлыг харгалзан тогтоож, мөрдөх. Төмөр замын байгууллага үнэ тариф болон түүний өөрчлөлтийн талаар нийтэд мэдээлнэ.

4/тээврийн болон бусад ажил, үйлчилгээний чанарын үзүүлэлт тогтоож, мөрдүүлэх;

5/төмөр замын тээврийн хэвийн ажиллагааг алдагдуулсан байгалийн гамшиг, осол, сүйрлийг арилгах, төмөр замын хөдөлгөөнийг нэн даруй сэрээх арга хэмжээг зөргөжлийн удирдлагаар хангаж, зохион байгуулах;

6/тээвэрлэж байгаа ачаа, тээш төмөр замын байгууллага, ажилтны буруутгаас алдагдсан, дутагдсан, гэмтсэн тохиолдолд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол учирсан хохирлыг гэрээнд заасан үнэ, эсхүл зарласан үнээр нөхөн төлөх. Ачаа, тээшийн дутагдал, гэмтэл, үнийг тогтоох боломжгүй бол шалган магадлах экспертизээр тогтоолгоно.

4. Төмөр замын байгууллага дор дурдсан эрхтэй байна:

1/төмөр замын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан шийдвэрийн дагуу төмөр замын

тээврийн үйл ажиллагаа эрхлэх, төмөр замын объектыг өмчлөх, төрийн өмчийн болон бусад төмөр замыг хууль, гэрээний дагуу ашиглах;

2/хэрэглэгч нь ачаа, тээшийг тогтоосон журмын дагуу аюулгүй байдлын нөхцөлийг ханган тээвэрлэлтэд бэлтгээгүй, илгээх ачааны үнийг ижил нэр, чанар бүхий барааны зах зээлийн үнээс өндрөөр зарласан, эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол тээврийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

3/гадаад орны болон дотоодын төмөр замын байгууллагатай тээврийн аюулгүй байдлыг хангах талаар хамтран ажиллах;

4/галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон хугацаанд явуулалгүй төмөр замын тээврийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан этгээдээс учруулсан хохирлыг төлөхийг шаардах;

5/төмөр замын шугамын тодорхой хэсгийг өргөтгөн шинэчлэх;

6/төмөр замын тусгай хамгаалалттай объект, гэрээгээр үйлчлүүлдэг байгууллагын салбар зам, дохиоллын хэрэгсэлд үзлэг, засвар үйлчилгээ хийх, салбар замын өвөр, арчилгааны норм зөрчигдсөн эсэхийг шалгаж хөдөлгөөний аюулгүй байдал зөрчигдөх, осол, сүйрэл гарах нөхцөл бий болсон үед уг объектын ашиглалтыг түр зогсоох.

5.Төмөр замын ажилтан дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэнэ. Дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журмыг төмөр замын байгууллагын дарга тогтооно.

18 дугаар зүйл.Төмөр замын тээврийн хяналтын алба

1.Төмөр замын байгууллагын дэргэдэх хяналтын алба нь тээврийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

2.Төмөр замын байгууллага Засгийн газраас эрх олгосны дагуу захиргааны хяналтыг хяналтын албаараа дамжуулан хэрэгжүүлнэ.

3.Хяналтын алба нь төмөр замын тээврийн үйлчилгээнд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хууль тогтоомж, төмөр замын объект, технологи, ажил үйлчилгээний стандарт, холбогдох бусад дүрэм, журам, зааврын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох чиг үүрэгтэй байна.

4.Хяналтын алба нь тээврийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /шаашид "улсын байцаагч" гэх/-аас бүрдэнэ.

5.Төмөр замын тээврийн улсын ерөнхий байцаагчийг төмөр замын байгууллагын даргын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

6.Төмөр замын тээврийн улсын ерөнхий байцаагч нь хяналтын албаны дарга байна.

7.Төмөр замын тээврийн улсын ахлах байцаагч, байцаагчийг төмөр

замын байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

19 дүгээр зүйл. Хяналтын албаны бүрэн эрх

1. Хяналтын алба дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/төмөр замын аюулгүй байдлыг хангах, төмөр замын тээврийн үйлчилгээг явуулах, зохицуулахтай холбогдсон хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

2/төмөр замын тээвэрт ашиглаж буй техник, төхөөрөмж, төмөр замын байгууллагын ажил, үйлчилгээ, технологийн горим нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, экологи, аюулгүй байдал, технологийн стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжид шалгах;

3/төмөр замын тээвэрт гарсан гологдол, осол, сүйрлийн шалтгааныг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, осол, сүйрэлд орсон төмөр замын объектод магадлагаа хийх, осол, сүйрлийн талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

4/төмөр замын объектын ашиглалт, хамгаалалт, төмөр замын байгууллагын бичиг баримт, салбар зам ашиглалтад хяналт тавих;

5/төмөр замын хяналтын мэргэжлийн ажилтан бэлтгэх, даван сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, тэдний ажиллах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулах;

6/тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал тавих.

2. Хяналтын албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3. Хяналтын албаны улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэх үедээ төмөр замын байгууллагын бүх төрлийн тээврийн хэрэгслээр эрхийн үнэмлэхээр үнэгүй зорчино.

20 дугаар зүйл. Төмөр замын байгууллагын цэрэгжүүлсэн хамгаалалтын алба

1. Төмөр замын байгууллагын цэрэгжүүлсэн хамгаалалтын алба /шашид "хамгаалалтын алба" гэх/ нь төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшийг гэмт халдлагаас хамгаалах, төмөр замын тээврийн салбарт галын аюулгүй байдлыг хангуулах, түүнд хяналт тавих, гал түймэртэй тэмцэх үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

2. Хамгаалалтын албаны ажилтан төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшийг гэмт халдлагаас хамгаалах, гал түймэр унтраах үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон, амиа алдсан бол түүнд буюу ар гэрт нь Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37 дугаар

зүйлийн 11 дэх хэсэгт заасан тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардлыг олгоно.

3.25-аас доошгүй жил тэтгэврийн давтгалын шимтгэл төлж төмөр замын хамгаалалтын албанд ажилласан ажилтан нас хэргэлэхдүйгээр Нийгмийн давтгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зардлыг төмөр замын байгууллага хариуцна.

5. Хамгаалалтын албаны ажилтан дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэнэ. Дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг Засгийн газар батална.

21 дүгээр зүйл. Хамгаалалтын албаны ажилтны бүрэн эрх

Хамгаалалтын албаны ажилтан дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ачаа, тээшинд үзлэг хийх, зөрчил гаргагчдын нэр хаягийг тодруулах, бичиг баримтыг үзэж шалгах, түр саатуулж, цагдаагийн байгууллага буюу холбогдох газарт хүргэх, мэдээлэх;

2/төмөр замын тээвэрлэлтэд хүлээлгэн өгсөн ачаа, тээшийн бүрэн бүтэн байдалд халдсан үйлдлийг таслан зогсоох;

3/төмөр замын аюултай бүсэд ажил үүргээ гүйцэтгэхээр нэвтрэн орох;

4/галт түймэр гарах бодит аюул учирсан үед холбогдох байгууллага, иргэдийн тодорхой үйлдлийг хэсэгчлэн буюу бүрэн хориглох, ажил үйлчилгээ явуулахыг түр зогсоох, холбогдох байгууллага, албан тушаалтанд асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;

5/байгалийн гамшиг, гэнэтийн аюул, төмөр замын осол, сүйрэл, үйлдвэрлэлийн бүлэг осол, галт түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед авах, хорио цээрийн дэглэмийг сахуулах ажиллагаанд оролцох;

6/төмөр замын тээврийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төмөр замын зарим объектыг төмөр замын байгууллагын даргын шийдвэрийн дагуу хамгаалах;

7/албан үүргээ гүйцэтгэж явах үедээ галт зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах.

22 дугаар зүйл. Хамгаалалтын албаны ажилтан тусгай хэрэгсэл,

мэх, галт зэвсэг хэрэглэх

1. Хамгаалалтын албаны ажилтан хяруул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үедээ халдлагын шинж байдлаас шалтгаалан резинэн бороохой, цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буюу, шүршүүр, резинэн буюу хуванцар сумтай буу, хамгаалах тусгай хэрэгсэл болон самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр

тулалдах мэх хэрэглэж, шаардалагатай бол албаны нохой ишиглаа болно.

2.Хамгаалалтад нь байгаа объектод нууцаар нэвтрэн орсон, эсхү, зэвсэг хэрэглэн, бүтэлтэн довтолсон үед уг үйлдлийг өөр арга, хэрэгсдээр таслан зогсоох боломжгүй бол хамгаалалтын албаны ажилтан гал зэвсэг хэрэглэж болно. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавры улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална.

3.Хамгаалалтын албаны ажилтан бололцоотой бүх тохиолдолд гал зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

4.Галт зэвсэг хэрэглэснээс хүний амь нас, эрүүл мэндэд хохиро, учирсан бол зэвсэг хэрэглэсэн хамгаалалтын албаны ажилтан эмнэлгийн каралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

5.Төмөр замын байгууллага хамгаалалтын албаны ажилтныг гал зэвсэг, тусгай хэрэгсдээр хангах ажлыг цагдаагийн байгууллагын хяналтын дор гүйцэтгэнэ.

23 дугаар зүйл. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөрийн харилцаа, сахилга

1.Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөрийн харилцаа дараахь шаардалагад нийцсэн байна:

1/ээлжийн ажилтны ажлын цагийн үргэлжлэх хугацаа 12 цага илүүгүй байх. Онцгой нөхцөлд ажлын цагийн үргэлжлэх хугацаа төмөр замын байгууллагын дарга, түүний орлогчийн тушаалаар 4 хүртэл цагаар сунгаж болно. Ээлжийн ажилтны нэгтгэн болсон ажлын ца нь тооцоот хугацаанд ногдох ажлын цагийн нийлбэрээс хэтэр болохгүй;

2/зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын эргэлтийн амра байранд амрах хугацаа нь өмнөх ажлын үргэлжлэх хугацааны хагасла багагүй буюу 3 цагаас доошгүй байна;

3/машинч, туслах машинчийг шөнийн ээлжинд 2-оос илүү уда ажиллуулахыг хориглоно;

4/зохиц сургалт хийж, тухайн ажлыг гүйцэтгэх эрх авсан, эрүү мэндийн хувьд ажлын шаардлага хангасан иргэнийг ажиллуулна. Эрүүл мэндийн үзлэг хийх хугацаа, журмыг эрүүл мэндийн асууда эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

2.18 насанд хүрээгүй хүмүүсийг галт тэрэгний хөдөлгөөнд шуу холбоотой ажилд ажиллуулж болохгүй. Тийм ажлын жагсаалты хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллаг батална.

3.Төмөр замын байгууллагын захиргаа болон ажилтны эрх үүрэг

хариуцлага, урамшуулал, төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны ажил, амралтын дэглэмийг төмөр замын ажилтны сахилгын тусгай дүрмээр зохицуулна.

4.Төмөр замын байгууллагын захиргаа хөдөлмөрийн сахилга зөрчсөн ажилтанд дараахь сахилгын шийтгэл ногдуулна:

1/сануулах;

2/хөдөлмөрийн хөлсийг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувь бууруулах;

3/албан тушаал, мэргэжлийн зэргийг 6 сар хүртэл хугацаагаар бууруулах;

4/төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх;

5/ажлаас халах.

24 дүгээр зүйл.Төмөр замын ажилтны нийгмийн баталгаа

1.Төмөр замын ажилтан дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

1/төмөр замын ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхдаа үйлдвэртэлийн ослын улмаас амь насаа алдсан бол нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэлэг ар гэрт нь олгоно;

2/төмөр замын байгууллагад тасралтгүй 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэйг төмөр замын байгууллагаас тэтгэвэрт гарахад нь зургаан сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэлэг олгоно;

3/төмөр замын ажилтан нь Монгол Улсын дотор төмөр замаар аялах тохиолдолд жилд нэг удаа ирэх, очих замд галт тэргээр үнэгүй зорчино.

2.Төмөр замын ажилтан хууль тогтоомжид заасан нийгмийн бусад халамж, баталгааг эдэлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийгмийн халамж, баталгаатай холбогдон гарах зардлыг төмөр замын байгууллага хариуцна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

25 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төмөр

замын тээврийн хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/энэ хуулийн 6 дугаар зүйлийн 7; 7 дугаар зүйлийн 1,2,3; 8 дугаар зүйлийн 2; 9 дүгээр зүйлийн 1,3; 11 дүгээр зүйлийн 2,4,5,9; 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2,3,4,5 дахь заалт; 2,3 дахь хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй буюу хориглосон үйл ажиллагаа явуулсан байгууллагыг 250000 хүртэл, албан тушаалтныг 50000 хүртэл төгрөгөөр торгох;

2/энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1,2,3,6,7,9; 7 дугаар зүйлийн 3,4,5; 9 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 3,4,5; 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй төмөр замын байгууллагыг 250000 хүртэл, төмөр замын ажилтныг 25000 хүртэл төгрөгөөр торгох.

3/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2,9,10; 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2,3,4,5,6; 2, 4 дэх хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй буюу хориглосон үйл ажиллагаа явуулсан иргэнийг 25000 хүртэл төгрөгөөр торгох;

4/зохих бичиг баримтгүй, жолоодох эрхгүйгээр төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг жолоодсон бол 30000-50000 төгрөгөөр торгох;

5/машинч, туслах машинч, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхтэй жолооч нь зүтгүүр төмөр замын тээврийн бусад хэрэгслийг согтуугаар жолоодсон бол жолоодох эрхийг нь 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл 30000-50000 төгрөгөөр торгох.

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох.

Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараахь агуулгатай заалт нэмсүгэй:

“9/улсын чанартай төмөр замын зурвас газар”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. Багабанди

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1955 оны “БНМАУ-ыг төмөр замын хөдөлгөөнийг аюулаас хамгаалах явдлыг хангах арга хэрэгжээний тухай” 126 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 7-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай
хууль тогтоомж

1. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ.

2. Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчим

Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь үндсэн зарчмыг баримтална:

1/хүүхдийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гэрэл, байдал, төрсөн газар, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар хүүхдийг ялгарлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах;

2/төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэх;

3/хүүхдийн бие бидлэр, оюун санаа, ёс суртахууны хөгжлийг хангах, сурч боловсроход эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч адил үүрэг хариуцлага хүлээх;

4/хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдрала оролцох эрхийг хангах явдал төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх;

5/хүүхэд мэдээлэл хайх, хүлээн авах, эвлэлдэн нэгдэх, шашин шүтэх, эх орноосоо гарах, буцаж ирэх эрх Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, нийгмийн дэг журам, үндэсний зан суртахуунд харилцахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эрх, журамт үүрэг

5 дугаар зүйл. Хүүхдийн амьдрах эрх

1. Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй. Хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.

2. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслэлээр санаатай гачигдуулах, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсээр хангахыг хориглоно.

3. Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай саналтаа илэрхийлэх эрхтэй.

4. Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж авах, тэтгэвэр тэтгэмж, асрамж, халамж хүртэх эрхтэй. Хүүхэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эмчилгээ болон эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдана. Энэ заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

5. Хүүхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга амьдрах, эх орондоо эргэн ирэх эрхтэй. Хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр оршин суух газрыг нь зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу өөрчилж болно.

6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх

1. Хүүхэд ерөнхий боловсролыг төлбөргүй эзэмших эрхтэй.

2. Хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших эрхтэй.

3. Хүүхэд оюун ухаан, авьяас билэг, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах эрхтэй.

4. Хүүхэд шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтийн дагуу хүүхэд шашны боловсрол элгож болно. Хүүхэд шашны үзэл номлолыг тулган хүлээлгэх, сүүхдийг хууран мэхлэх замаар шашны үйл ажиллагаанд татан

оролцуулах, шашны сургууль, сүм хийдэд албадан суулгахыг хориглоно.

5. Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх эрхтэй. Хүүхдэд гэмт хэрэг, садар самуун, хүчирхийллийг сурталчлах, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд өөрөө хүсээгүй бол хүүхдийг сурталчилгаанд ашиглахыг хориглоно.

7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх

1. Хүүхдийг гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эхээс нь тусгаарлаж болно. Энэ нөхцөлд хүүхэд төрийн асрамжид байна.

2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

3. Хүүхэд хувийн болон захидал харилцааны нууц, орон байрны халдангуй байдалаа хамгаалуулах эрхтэй.

4. Хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, хүчирхийлэл, мөрийтэй тоглоом, садар самуун, насанд хүрэгчдийн хоорондын аливаа зөрчил, архи, тамхи, мансууруулах болон хордуулах бодис хэрэглэхэд татан оруулах; доромжлох, басамжлах, гүтгэх, хүчирхийлэх, хулгайлах, барьцаанд авах, худалдах; санаатай солих, хаях, төөрүүлэх; тарчлаан зовоох, тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаанд ашиглах, бага насанд нь сүй тавьж албадан гэрлүүлэх; хууль бусаар үрчлэх, хорьж цагдах, гадаадад авч гарах, гадаадаас оруулж ирэхийг хориглоно.

5. Төрийн байгууллага, албан тушаалтан хорих ял эдэлж байгаа хүүхдийн нэр төрийг хүндэтгэн хамгаалж, сурч боловсрох, авьяас чадвараа хөгжүүлэх, хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт албадан саатуулах, цагдан хорихыг хориглоно.

6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдээр ёс суртахуун, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр зохлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөжлөгийн хэлбэрээр ашиглах, тэдний хөдөлмөрийн хөлсийг шударга бусаар тооцож олгох, гуйлга гуйлгах, хууль бусаар нэрээр нь ашиг олох үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

8 дугаар зүйл. Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрх

1. Хүүхэд нас, биеийнхээ онцлог, эрүүл мэндэд тохирсон тоглоом, наадам, соёл урлаг, биеийн тамир, аялал жуулчлалын арга хэмжээнд оролцох, амрах эрхтэй.

2. Хүүхдийн олон нийтийн байгууллагад сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх

эрхтэй. Хүүхдэд аль нэг улс төрийн үзэл сургаал тулган хүлээлгэх, бага насны хүүхдийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулахыг хориглоно.

3.Хүүхэд өөрт нь зориулсан сургалт, эмчилгээ, асрамж, сувилал, бусад үйлчилгээнд үнэтлэл өгөх, энэ талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

4.Хүүхэд өөрийн бүтээсэн оюуны үнэт зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх эрхтэй.

5.Хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй.

9 дүгээр зүйл.Хүүхдийн журамт үүрэг.

Хүүхэд дараахь журамт үүрэг хүлээнэ:

1/эцэг эхээ хайрлах, бусад хүнийг хүндэтгэх, тэдэнд туслах;

2/эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;

3/суурь боловсрол заавал эзэмших;

4/төрийн хууль ёсыг сахиж, ард түмний өв уламжлалыг дээдлэн хүндэтгэх, эзэмших;

5/эрүүл мэндээ хамгаалах;

6/авьяас чадвараа хөгжүүлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон
түмний оролцоо

10 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг хамгаалах талаар Засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрх

Хүүхдийн эрхийг хамгаалах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах;

2/хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

3/хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж,хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4/хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий хүүхдийн сургалт хүмүүжил, амралт, хэвтэл, мэдээллийн болон халамжлан хүмүүжүүлэх, асарч сувилал, түр саатуулах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэх.

11 дүгээр зүйл Хүүхдийн эрхийг хамгаалах талаар иргэдийн
Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын
хэрэгжүүлэх бүрэн эрх

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

2/хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

3/хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засаг даргын явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих;

4/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах арга хэмжээ авах, энэ талаар гарсан үүсгэл санаачилгыг дэмжих;

2/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах арга хэмжээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

3/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах чиг үүрэг бүхий хүүхдийн сургалт, соёл, хүмүүжил, амралт, хэвлэл, мэдээллийн болон халамжлан хүмүүжүүлэх, асарт сувилах, түр сэлтүүлэх байгууллагыг байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааг нь хянаж шалгах;

4/хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн байгууллагын ажлыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5/онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг судлан тогтоож, тэдний эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах;

6/холобогдох байгууллага, албан тушаалтан, иргэний санал хүсэлт, шүүхийн шийдвэрийг үндэслэн хүүхдийг төрийн асрамжинд авах;

7/төөрсөн, орон гэрээсээ дайжсан болон бусад шалтгаанаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургууль,

цагдаагийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг оролцуулах;

8/хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, хүүхдийн зориулалтын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих;

9/хүүхдийн эрхийг хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гургасан санаачилга, хүүхдийн олон нийтийн байгууллагыг дэмжих, хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

10/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3 Баг, хорооны Засаг дарга хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний санал хүсэлтийг судлах, шийдвэрлэх буюу шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах;

2/тухайн баг, хорооны харьяат хүүхдийн талаар судалгаа гаргаж, шаардлагатай мэдээллийг дээд шатны Засаг дарга болон холбогдох байгууллагад өгөх, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг

1. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараахь үүрэг хүлээнэ:

1/хүүхдийн амьдрах эрүүл орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлээр хангах;

2/хүүхдэд удам угсаагаа мэдүүлж, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг эзэмшүүлэх;

3/хүүхдэд эх орон, ард түмэн, эцэг эх, ах дүү, төрөл садан, бусад хүнийг хайрлан хүндэтгэх үзэл, үнэнч шударга, гэвчээр хатуужилтай зан чанар, харилцааны соёл төлөвшүүлэх;

4/хүүхдийг арихдах, мансуурахад донтох, садар самуунд автах, эмт хэрэг, эрх зүйн зөрчилд ортохоос сэргийлэх, хамгаалах;

5/хүүхдийг сурган хүмүүжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд зургууль, хамт олон, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийн дэмжлэг тусалшааг авч, хамтран ажиллах;

6/хүүхдийг эрүүл мэндийн болон хууль тогтоомжид заасан бусад шатгал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах;

7/хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх;

8/хүүхдэд журамт үүргээ биелүүлэхэд нь туслах;

9/хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу арилгах;

10/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

2.Эцэг, эх тусдаа амьдрах болсон, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

13 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд тусламж дэмжлэг үзүүлэх;

2/хүүхдэд оюун санаа, ажил үйлс, ёс суртахууны хувьд сайн үлгэр дуурнал үзүүлж, тэднийг сурган хүмүүжүүлэхэд санаа тавьж, холбогдох арга хэмжээ авах;

3/онцгой, хүнд нөхцөлд байгаа хүүхдэд сэтгэл санаа, эд хөрөнгийн болон бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх;

4/хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд санал болгох;

5/хүүхдийн олон нийтийн байгууллага, хүүхдийн ордон, зуслан, номын сан, театр, хэвтэл мэдээллийн газар, соёл хүмүүжлийн ба халамжийн төв зэрэг байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

6/хүүхдийн хөгжилд хохирол учруулах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх, хүмүүжил, ёс суртахуунд нь сөрөг нөлөө үзүүлэх мэдээлэл тархах, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах зэрэг үйл ажиллагаа явуулахгүй байх;

7/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж

14 дүгээр зүйл. Хүүхдийг нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах

Хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлт, нийгмийн даатгалд хамруулах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.

15 дугаар зүйл. Онцгой ба хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламж

1. Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ. Ийм нөхцөлд байгаа хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх асуудлыг Засгийн газар тухай бүр шийдвэртлэнэ.

2. Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүнд нөхцөлд байгаа хүүхдэд дараахь халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлнэ:

1/боловсрол, мэргэжил эзэмшихэд туслалцаа үзүүлэх;

2/эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох;

3/хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох.

3. Өвлөх хөрөнгөгүй бүтэн өнчин хүүхэд төрийн асрамжаас гарахад орон нутгийн төрийн захиргааны байгууллага орон байраар хангана.

4. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг, садар самуунд өртсөн хүүхдийг цагдаа, эрүүл мэнд, боловсролын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн байнгын хяналтад байлгаж, эмчлэх, сувилах, хүмүүжүүлэх арга хэмжээ авна.

5. Хараа хяналтгүй, хаяг нь тодорхойгүй, гэр бүлдээ өсч хүмүүжих, суралцах боломжгүй, эрх нь зөрчигдөж байгаа болон хэрэг зөрчилд холбогдсон хүүхдийг түр саатуулах, халамжлах, хөдөлмөр хүмүүжлийн байгууллагад сурган хүмүүжүүлэх зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. Хүүхдийг түр саатуулах, халамжлах болон хүүхдийн хөдөлмөр хүмүүжлийн байгууллагын байр, танхим нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага,
түүний чиг үүрэг

16 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төв байгууллага

1. Хүүхдийн талаар явуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг тун амын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сариуцна.

2. Хүн амын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний

дэргэд хүүхдийн төлөө үндэсний байгууллага байна.

3.Хүүхдийн төлөө үндэсний байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/хүүхдийн талаар явуулах төрийн бодлого, хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах зорилго бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах;

3/хүүхдийн асуудал эрхэлсэн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

4/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах чиг үүрэгтэй олон нийтийн байгууллагад арга зүйн туслалцаа үзүүлэх;

5/хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

4.Хүүхдийн төлөө үндэсний байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

17 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага

1.Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг харьца нутаг дэвсгэрийнхэр хэмжээнд Засаг дарга хариуцна.

2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд хүүхдийн төлөө байгууллага байна.

18 дугаар зүйл.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл

1.Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд нийгмийн нооц баалтийг дайчлах, төр, олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж,иргэдийг оролцуулах үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл байна.

2.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүдэх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд төр, олон нийт,шашны байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгч, улс төр, нийгэм, соёлын зүтгэлтэн,иргэд оролцоно.

3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг Хүүхдийн төлөө үндэсний байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд, дүрмийг зөвлөл өөрөө батална.

19 дүгээр зүйл.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үүрэг

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл дараахь үндсэн үүргийг хэрэгжүүлнэ:

1/хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих;

2/хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтны тайлан, мэдээллийг сонсох, энэ талаар цаашид авах арга хэмжээний тухай саналыг Засгийн газар, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

3/хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, тэдгээрийн гэтгэсэн санал, санаачилгыг дэмжих;

4/хүүхдийн төлөө сан байгуулж, түүний орлого, зарлагын төсвийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, олон нийтэд мэдээлэх;

5/хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд идэвх зүтгэл гаргаж, гавьяа байгуулсан хүүхэд, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнах, урамшуулах тухай саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих;

6/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

7/хууль тогтоомжилд заасан бусад үүрэг.

20 дугаар зүйл. Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл байна.

2. Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга батална.

3. Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үүргийг Засаг даргын дэргэдэх хүүхдийн төлөө байгууллагаар гүйцэтгүүлдэг.

4. Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн дүрмийг уг зөвлөл өөрөө батална.

21 дүгээр зүйл. Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах олон нийтийн байгууллага

1. Хүүхдүүд сайн дураараа эвлэлдэн нэгдэж, хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах зорилго бүхий олон нийтийн байгууллагыг байгуулж болно.

2. Насанд хүрэгчид хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйлсэд туслах зорилгоор олон нийтийн байгууллага байгуулан ажиллаж болно.

22 дугаар зүйл. Хүүхдийн төлөө сан

Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах зорилгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүүхдийн төлөө зөвлөлийн дэргэд Хүүхдийн төлөө сан байгуулж болно. Хүүхдийн төлөө сангийн дүрмийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай
хууль тогтоомжийн биелэлтэд
хяналт тавих

1. Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

2. Хүүхдийн болон бусад олон нийтийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина.

24 дүгээр зүйл. Хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээх талаар
гомдол, нэхэмжлэл гаргах

1. Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжилд заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана.

2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хууль тогтоомжилд заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргаж болно.

3. Хүүхдийн төлөө байгууллага, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан ажилтан эрх нь зөрчигдсөн хүүхдийг төлөөлөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон холбогдох албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавьж, зайлшгүй тохиолдолд зохих арга хэмжээ авахуулахаар Засаг дарга, төрийн байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргана.

25 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх
хариуцлага

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;

2/хүүхдийг хувиас, хоол хүнс, орон байраар санаатай гачигдуулсан, хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг санаатай хэрэгслүүлсэн иргэн, албан тушаалтныг 15000-25000 төгрөгөөр торгох;

3/хүүхдийг эрүүл мэндийн урьтчилан сэргийлэх тарилга, эрүүл мэндийн даатгалд санаатайгаар хамруулаагүй иргэн, албан тушаалтныг 5000-10000 төгрөгөөр торгох;

4/хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээр төлбөл зохих тэтгэлийг төлүүлж, түүнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;

5/хүүхдээр гуйлга гуйлгасан иргэн, эрүүл мэндэд нь харшлах ажил хөдөлмөр хийлгэсэн албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох;

6/өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох үйл ажиллагаа явуулсан иргэн, албан тушаалтны олоон ашиг, орлогыг хурааж, 20000-30000 төгрөгөөр торгох;

7/хүүхдийг хууран мэхлэх буюу эд хөрөнгөөр татах замлар шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан, сүм хийлдэ албадан суулгасан иргэнийг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

8/төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ халсан, төөрүүлж орхисон иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зарга мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ХАРАА ХЯНАЛТГУЙ ХҮҮХДИЙГ ТҮР СААТУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "... 48 цаг" гэснийг "... 7 хоног" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хуулийн 85 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүмүүсийг эцэг, эх, харгалзан дэмжигч болон хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр ажиллуулж болно."

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн хуулийн 35 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Тэдний ээлжийн амралтыг тухайн жилдээ хүссэн үед нь олгоно." гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хөдөлмөрийн хуулийн 74 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг, 85 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 4 дээ хэсэг тус тус нэмсүгэй:

74 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Тахир дутуу болон бие эрхтний эмгэг согогтой насанд хүрээгүй хүнийг нийгмийн халамж, хамгааллын асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагын зөвшөөрөл, хяналттайгаар хөдөлмөр эрхлүүлж болно.”

85 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4 Энэ зүйлийн 1,2,3 дахь хэсэгт заасан хүнийг ажилд авахдаа түүнтэй энэ хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулна.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай 105¹ дугаар зүйл нэмсүгэй:

“105¹ дугаар зүйл. Хүүхэд хаях, төөрүүлэх

Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлж орхисон бол гурван жил хүртэл хутагцаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хутагцаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 151¹ дүгээр зүйлийн заалтыг мөн зүйлийн 1 дэх хэсэг болгож, дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

“2 Шашины сургууль, сүм хийдэд хүүхдийг албадан суулгасан, хууран мэхлэх буюу эд хөрөнгөөр татах замаар шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан, шашин үзэл номлолыг тулган хүлээлгэсэн бол гурван жил хүртэл хутагцаагаар хорих ял шийтгэнэ.”

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 105 дугаар зүйлийн нэрийн “... солих” гэсний дараа, “худалдах, хууль бусаар үрчлэх,” мөн зүйлийн 1 дэх хэсгийн “... санхатай сольсон” гэсний дараа, худалдсан, хууль бусаар үрчилсэн”, 241 дүгээр зүйлийн “... ууж согтуурах” гэсний дараа, “мансууруулах болон хордуулах бодис хэрэглэх,” 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... давтан үйлдсэн” гэсний дараа, “түүнчлэн

мансууруулах бодисыг хүүхдэд худалдсан, эсхүл тэднээр худалдуулсан, энэ үйлдэлд бусад хэлбэрээр хүүхдийг оролцуулсан” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3 Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

а/Удирдлагын ерөнхий чиг үүргийн яамд:

1. Монгол Улсын Сангийн яам;

2. Монгол Улсын Гадаад харилцааны яам ;

3. Монгол Улсын Хууль зүйн яам;

б/Чиглэлийн яамд:

1. Монгол Улсын Байгаль орчны яам;

2. Монгол Улсын Батлан хамгаалах яам;

3. Монгол Улсын Гэгээрлийн яам;

4. Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн яам;

5. Монгол Улсын Хөлөө аж ахуй, үйлдвэрийн яам;

6. Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам”.

2 дугаар зүйл. Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 16 дахь заалт, 33 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн эхний огуулбэрийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтоосугай:

- 1) Монгол Улсын Ерөнхий сайд;
- 2) Монгол Улсын Байгаль орчны сайд;
- 3) Монгол Улсын Батлан хамгаалахын сайд;
- 4) Монгол Улсын Гадаад харилцааны сайд;
- 5) Монгол Улсын Гэгээрлийн сайд;
- 6) Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайд;
- 7) Монгол Улсын Сангийн сайд;
- 8) Монгол Улсын Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд;
- 9) Монгол улсын Хууль зүйн сайд;
- 10) Монгол улсын Эрүүд мэнд, нийгмийн хамгааллын сайд.

2 дугаар зүйл. "Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай" 1992 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн Монгол Улсын хууль, "Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" 1993 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн Монгол Улсын хууль, "Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1994 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн Монгол Улсын хуулийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 7 дугаар
сарын 26-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 33 дугаар

зүйлийн 3 дахь хэсгийг "3.Ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 7 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Цагдаагийн байгууллагын тогтолцоо нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа албад, аймаг, нийслэлийн харьяа албад болон аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/, сум, дүүргийн буюу сум, дүүрэг дундын цагдаагийн хэлтэс /газар, хэсэг/-ээс бүрдэнэ".

2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Засгийн газар Монгол Улсын Хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын
гишүүдийн бүрэн эрхийг
хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их хурлын 1996 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болсон ээлжит сонгуулийн нэгдсэн дүн, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Сонгуулийн Ерөнхий Хорооны илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон хавсралтад заасан нэр бүхий 76 гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Хуралдааны дарга

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Их Хурлын 1 дүгээр
тогтоолын хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ

Аймаг, нийслэлийн дүүргийн нэр	Тойргийн дугаар	Овог, нэр
Архангай	1	Раднаасүмбэрэлийн Гончигдорж
	2	Санжбэгийн Төмөр-Очир
	3	Самбуугийн Ламбаа
Баян-Өлгий	4	Рагзэгийн Сандалхан
	5	Таужейн Султан
	6	Ажанын Болат
Баянхонгор	7	Ёндон-Ойловын Гэрэлчулуун
	8	Даржаагийн Батнасан
	9	Шагнагийн Элбэгдорж
Булган	10	Ямалранзын Эрхэмбаяр
	11	Данзанхорлоогийн Дашпүрэв

Говь-Алтай	12	Пунцагийн Жасрай
	13	Аюурзанын Базархүү
Говь-Сүмбэр	14	Ёндонпунцагийн Адилбиш
Дорноговь	15	Цэрэнхүүгийн Шаравдорж
Дорнод	16	Дамдинсүрэнгийн Энхбаатар
	17	Санжаласүрэнгийн Зориг
	18	Соёлсүрэнгийн Билэгсайхан
Дундговь	19	Норжмаагийн Тогтох
	20	Жамьяангийн Отгонбаяр
Завхан	21	Нацагийн Багабанди
	22	Цэрэндоржийн Ганхуяг
	23	Намдагийн Батцэрэг
Өвөрхангай	24	Хэнмэдхэвийн Дашзэвэг
	25	Рагчаагийн Баламдамдин
	26	Данзангийн Лүндээжанцан
	27	Шийлэгийн Батбаяр
Өмнөговь	28	Чүлтэмийн Отгонбаяр
	29	Цэвэлмаагийн Баярсайхан
Сүхбаатар	30	Чүлтэмийн Улаан
	31	Очирбатын Дашбалбар
Сэлэнгэ	32	Дониогийн Цогт-Очир
	33	Сангжавын Баярцогт
	34	Рэнцэнгийн Содхүү
Төв	35	Догсомын Ганболд
	36	Мэндийн Зэнээ
	37	Сандагийн Гончиг
	38	Үнэнбүрэнгийн Наранцэцэг
Увс	39	Цэндийн Нямдорж
	40	Налмидын Баяртсайхан
	41	Сорьгоогийн Төмөр
Ховд	42	Жамсралгийн Бямбадорж
	43	Жамбын Норовсамбуу
	44	Дамдингийн Дэмбэрэл
Хөвсгөл	45	Должингийн Цогбалдрах
	46	Эрлэнийн Бат-Үүл
	47	Рэнчинсамбуугийн Одонбаатар
	48	Данзангийн Бохыцарга

Хэнтий	49	Даваадоржийн Ганболд
	50	Нямаагийн Төвшинтөгс
	51	Ойдовын Энхтуяа
Дархан-Уул	52	Төмөр-Очирын Эрдэнэбилэг
	53	Мишигийн Чимэдцэрэн
	54	Шаравжамцын Батбаяр
Орхон	55	Луузангийн Лувсан-Очир
	56	Данзанбалжирын Энхтайван
Баянзүрх	57	Сэрээтэрийн Болдхэт
	58	Хашбатын Хулан
	59	Цэвээндоржийн Төмөртогтоо
Налайх	60	Саригийн Батчулуун
Хан-Уул	61	Түвдэнгийн Очирхүү
	62	Галсанпунцагийн Ганхуяг
Баянгол	63	Бат-Эрдэнийн Батбаяр
	64	Ринчиннямын Амаржаргал
	65	Төгсжаргалын Ганди
	66	Жамбын Гомбожав
Сонгино	67	Альяагийн Ганбаатар
	68	Чимэдийн Сайханбилэг
	69	Норовын Алтанхуяг
	70	Дашжамцын Баттулга
Чингэлтэй	71	Батжаргалын Батбаяр
	72	Ринчингийн Нарангэрэл
	73	Долгорын Хувьтөгөлдөр
Сүхбаатар	74	Лувсанвандангийн Болд
	75	Банзрагчийн Дэлгэрмаа
	76	Цагаандарийн Энхтүвшин

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот -

Санал хураах комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын даргыг сонгох санал хураалтыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Р. Одонбаатар
Нарийн бичгийн дарга:	Ё. Адилбиш
Гишүүд:	С. Батчулуун
	Р. Нарангэрэл
	Р. Содхүү

Хуралдааны дарга

П. ЖАСРАЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын
даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасныг баримтлан, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн Гончигдоржийг сонгосугай.

Хуралдааны дарга

П. ЖАСРАЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Санал хураах комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилж санал хураалтыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Р. Одонбаатар
Нарийн бичгийн дарга:	Ж.Бямбадорж
Гишүүд:	С. Батчулуун
	Р. Нарангэрэл
	Р. Солхүү

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхий сайдыг
томилж тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Мэндсайханы Энхсайханыг томилсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг 1996 оны 7 дугаар сарын 19-ний дотор, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай саналаа 7 дугаар сарын 23-ны дотор багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайханд таалгасугай.

3. Монгол Улсын шадар сайд, сайд нар Монгол Улсын Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнийг томилогдох хүртэл үүргээ гүйцэтгэж зайхаар тогтоосугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**Улсын Их Хурлын дэд даргыг
сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8,23 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их хурлын дэд даргад нэр дэвшүүлэн хэлэлцэж, нууцаар санал хураасан тухай санал хураах комиссын тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Цахиагийн Элбэгдоржийг сонгосугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 8,33 дугаар зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Санжалсүрэнгийн Зоригийг сонгосугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Н. Багабандийн хамгаалалт,
хангамжийн тухай**

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Улсын Их Хурлын даргын алба хашиж байсан Нацагийн Багабандийг нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамгаалах ажлыг Төрийн тусгай хамгаалалтын газарт хариуцуулсугай.

2. Мөн хугацаанд Н. Багабандид суудлын автомашинаар үйлчилж байхыг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**П. Жасрайгийн хамгаалалт,
хангамжийн тухай**

Монгол Улсын Засгийн газрын хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Пунцагийн Жасрайг нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамгаалах ажлыг төрийн тусгай хамгаалалтын газарт хариуцуулсугай.

2. Мөн хугацаанд П. Жасрайд суудлын автомашинаар үйлчилж байхыг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын Байнгын
хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8, 13 дугаар зүйлд заас-
ныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэ-
хүүнтэйгээр байгуулсугай:

1. Нийгмийн бодлогын байнгын хороо:

1. Норовын Алтанхууг
2. Нацагийн Багабанди
3. Шаравжамшын Батбаяр
4. Шийлэгийн Батбаяр
5. Даржаалгийн Батнасан
6. Намдагийн Батцэрэг
7. Данзангийн Бохьшарга
8. Адьвагийн Ганбаатар
9. Төгсжаргалын Ганди
10. Цэрэндоржийн Ганхууг
11. Данзанхорлоогийн Дашпүрэв
12. Банзрагчийн Далгэрмаа
13. Пунцагийн Жасрай
14. Самбуугийн Ламбаа
15. Ринчингийн Нарангэрэл
16. Үнэнбүрэнгийн Наранцэнцэг
17. Цэндийн Нямдорж
18. Чүлтэмийн Спонбаяр
19. Түвдэнгийн Очирхүү
20. Нөржмаагийн Тогтох
21. Санжбэгзийн Төмөр-Очир
22. Хашбатын Хулан
23. Долгорын Хувьтөгөлдөр
24. Чимэдийн Сайханбилэг
25. Цагаандарийн Энхтүвшин

26.Төмөр-Очирын Эрдэнэбилэг

II.Төрийн байгуулалтын байнгын хороо.

- 1.Ёндонпунцагийн Адилбиш
- 2.Нацагийн Багабенди
- 3.Бат-Эрдэнийн Батбаяр
- 4.Эрдэнийн Бат-Үүл
- 5.Намдалгийн Батцэрэг
- 6.Данзангийн Бөхшарга
- 7.Жамсрангийн Бямбалорж
- 8.Сангажавын Балрцогт
- 9.Цэвэлмаагийн Бакрсайхан
- 10.Төгсжаргалын Ганди
- 11.Адъяагийн Ганбаатар
- 12.Догсомын Ганболд
- 13.Галсанпунцагийн Ганхуяг
- 14.Жамбын Гомбожав
- 15.Раднаасүмбэрэлийн Гонигдорж
- 16.Очирбатын Дашбалбар
- 17.Хэнмэдхэвийн Дашзэвэг
- 18.Данзанхорлоогийн Дашпүрэв
- 19.Санжаасүрэнгийн Зориг
- 20.Мэнцийн Зэнээ
- 21.Пунцагийн Жасрай
- 22.Данзангийн Лүндээжаншан
- 23.Ринчингийн Нарангэрэл
- 24.Рэнчинсамбуугийн Одонбаатар
- 25.Жамьянгийн Отгонбаяр
- 26.Чүлтэмийн Отгонбаяр
- 27.Цэвээндоржийн Төмөртоого
- 28.Сорогжоогийн Төмөр
- 29.Дониогийн Цогт-Очир
- 30.Мишигийн Чимэцшэрэн
- 31.Хашбатын Хулан
- 32.Цэрэнсүүгийн Шаравдорж
- 33.Дамдинсүрэнгийн Энхбаатар
- 34.Ойдовын Энхтуяа
- 35.Цагаандарийн Энхтүвшин
- 36.Ямаранзын Эрхэмбаяр

III.Төсө, санхүү, мөнгө зээлийн бодлогын байнгын хороо:

1. Ринчиннямын Амаржаргал
2. Рагчаагийн Бадамдамдин
3. Аюурзанын Базархүү
4. Бат-Эрдэнийн Батбаяр
5. Дашжамцын Баттулга
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Надмидын Баярсайхан
8. Сангажавын Байрцогт
9. Соёлсүрэнгийн Билэгсайхан
10. Ажханы Болат
11. Лувсанвандангийн Болд
12. Сэрээтэрийн Болдхэг
13. Адыаагийн Ганбалтар
14. Даваадоржийн Ганболд
15. Цэрэндоржийн Ганхуяг
16. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
17. Дамдингийн Дэмбэрэл
18. Санжаасүрэнгийн Зориг
19. Самбуугийн Ламбаа
20. Луузангийн Лувсан-Очир
21. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
22. Жамбын Норовсамбуу
23. Түвдэнгийн Очирхүү
24. Радаагийн Сандагхан
25. Нямалгийн Түвшинтөгс
26. Чүлтэмийн Улаан
27. Дониогийн Цогт-Очир
28. Данзанбалжирын Энхтайван
29. Сядовын Энхтуяг
30. Ямааранзын Эрхэмбаяр

IV.Хөдөөгийн бодлого, байгаль орчны байнгын хороо:

1. Рагчаагийн Бадамдамдин
2. Батжаргалын Батбаяр
3. Шаравжамцын Батбаяр
4. Даржаагийн Батнасан
5. Намдагийн Батцэрэг
6. Цэвэлмаагийн Баярсайхан

7. Надмидын Баяртсайхан
8. Данзангийн Бохьшарга
9. Цэрэндоржийн Ганхуяг
10. Жамбын Гомбожав
11. Сандагийн Гончиг
12. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
13. Хэнмэдхэвийн Дашзэвэг
14. Данзангийн Лүндээжанцан
15. Жамбын Норовсамбуу
16. Жамъянгийн Отгонбаяр
17. Рэнцэнгийн Содхүү
18. Таухейн Султан
19. Санжбэгзийн Төмөр-Очир
20. Цэвээндоржийн Төмөртоогоо
21. Нямаагийн Түвшинтөгс
22. Долгорын Хувьтогөлдөр
23. Должингийн Цогбадрах
24. Данзанбалжирын Энхтайван

У.Хууль зүйн байнгын хороо:

1. Ёндонпунцагийн Ашилбиш
2. Норовын Алтанхуяг
3. Ринчиннямын Амаржаргал
4. Рагчаагийн Бадамдамдин
5. Эрдэнийн Бат-Үүл
6. Саригийн Батчулуун
7. Соёлсүрэнгийн Билэгсайхан
8. Ажханы Болат
9. Лувсанвандангийн Болд
10. Жамсрангийн Бямбадорж
11. Даваадоржийн Ганболд
12. Догсомын Ганболд
13. Очирбатын Дашбалбар
14. Банзрагчийн Дэлгэрмаа
15. Мэндийн Зэнээ
16. Луузангийн Лувсан-Очир
17. Цэндийн Нямдорж
18. Чүлтэмийн Отгонбаяр
19. Чимэдийн Сайханбилэг
20. Сорогжоогийн Төмөр

21. Долгорын Хувьтогдлоор
22. Цэрэнхүүгийн Шаравдорж
23. Шахиагийн Элбэгдорж
24. Дамдинсүрэнгийн Энхбаатар
25. Ойдовын Энхтуяа
26. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

ҮІ. Эдийн засгийн бодлогын байнгын хороо:

1. Норовын Алтанхуяг
2. Ринчиннямын Амаржаргал
3. Аюурзанын Базархүү
4. Шийлэгийн Батбаяр
5. Дашжамцын Баттулга
6. Лувсанвандангийн Болд
7. Сэрээтэрийн Болдхэг
8. Дяваадоржийн Ганболд
9. Догсомын Ганболд
10. Галсангунцагийн Ганхуяг
11. Сандагийн Гончиг
12. Банзрагчийн Дэлгэрмаа
13. Дамдингийн Дэмбэрэл
14. Луузангийн Лувсан-Очир
15. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
16. Рэнчинсамбуугийн Одонбаатар
17. Түвдэнгийн Очирхүү
18. Рахдагийн Сандатман
19. Рэнцэнгийн Содхүү
20. Таукейн Султан
21. Норжмаагийн Тогтох
22. Нямаагийн Түвшинтөгс
23. Чүлтэмийн Улаан
24. Хашбатын Хулэн
25. Должингийн Цогбадрах
26. Донногийн Цогт-Очир
27. Мишигийн Чимэдгэрэн
28. Данзанбалжирын Энхтайван
29. Ямааранзын Эрхэмбаяр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын Байнгын хороодын
даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан журмын дагуу нэр дэвшүүлж, санал хуралтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Хашбатын Хулси;
2. Төсөл, санхүү, мөнгө, эзлийн бодлогын байнгын хорооны даргаар Адъяагийн Ганбаатар;
3. Хөдөөгийн бодлого, байгаль орчны байнгын хорооны даргаар Цэвэлмэргийн Баярсайхан;
4. Хууль, зүйн байнгын хорооны даргаар Саригийн Багчулуун;
5. Эдийн засгийн бодлогын байнгын хорооны даргаар Давсдоржийн Ганболд нарыг тус тус сонгосугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын бүтэц,
бүрэлдэхүүн батлагасантай холбогдуулан
авх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилуулал хүнийг
гсуудлыг энэ оны 7 дугаар сарын 27-нд багтаан Улсын Их Хуралд
эргэн мэдүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхсайханд
балгасугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилдох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдааг; Нехиогийн Адьяасүрэнг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилдох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдааг; Жүгтээгийн Амарсанааг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдаар Галсандаргын Нямдавзэг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар (унцагийн) Цагааныг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын
гшгүүнийг томлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Дамбийн Дорлигжавыг томилсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын
гшгүүнийг томлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайдаар Чүлтэмийн Лхагважавыг томилсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тунхи есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөлөө аж ахуй, үйлдвэрийн сайдаар Лувсанбалдангийн Намсамбууг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тунхи есдүгээр зүйлийн гурав дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгүүдийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн амгаланлын сайдаар Лхагважавын Зоригийг томилсугай.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг ажлаас
чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан:

1. Чойжилсүрэнгийн Пүрэвдоржийг Монгол Улсын Шадар сайдын;
2. Лхамсүрэнгийн Энэбишийг Монгол Улсын Шадар сайдын;
3. Чүлтэмийн Улааныг Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын даргын;
4. Замбын Батжаргалыг Монгол Улсын Байгаль орчны сайдын;
5. Шагалын Жадамбааг Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын;
6. Цэрэнпилгийн Гомбосүрэнг Монгол Улсын Гадаад харилцааны сайдын;
7. Раздакын Сандалханыг Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын;
8. Эрдэнийн Бямбажавыг Монгол Улсын Сангийн сайдын;
9. Намбарын Энхбаярыг Монгол Улсын Соёлын сайдын;
10. Цэвэгмидийн Цогтыг Монгол Улсын худалдаа, үйлдвэрийн сайдын;
11. Намсрайжавын Лувсанжавыг Монгол Улсын Хууль зүйн сайдын;
12. Эрдэнийн Гомбожавыг Монгол Улсын Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын;
13. Цэвээнжавын Өөлдийг Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайдын;
14. Санжбэгийн Төмөр-Очирыг Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдын;
15. Пагважавын Нямдавааг Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын ;
16. Бямбын Жигжидийг Монгол Улсын Эрчим хүч, геологи, уул уурхайн сайдын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар
хот

**Д. Пүрэвдоржид Монгол Улсын
ардын зохиолч цол олгох тухай**

Уран зохиолын салбарт үр бүтээлтэй ажиллаж ардын аман зохиолын уламжлалыг яруу найргийн орчин үеийн сэтгэлгээгээр баяжуулан уншигч түмний таашаалд нийцсэн олон сайхан шүлэг, найраглал туурвиж шинэ цагийн шүлэглэлт зохиолыг хөгжүүлэхэд оруулсан дорвитой хувь нэмрийг нь үнэлж Дэндэвийн Пүрэвдоржид Монгол Улсын ардын уран зохиолч цол олгосутай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

**Б. Зангад Монгол Улсын ардын
жүжигчин цол олгох тухай**

Ардын болон мэргэжлийн хөгжмийн зохиолчдын дуу, өрнөдийн сонгодог дуурийн ари, романс зэрэг 200 гаруй бүтээлээр урын сангаа баяжуулан, 40 гаруй жил цээл сайхан хоолойгоор дуулж сонсогч олноо хаясгахын зэрэгцээ урлагийн байгууллагыг олон жил чадварлаг зохион байгуулан удирдаж, урлаг соёлыг хөгжүүлэхэд оруулж байгаа их хувь нэмрийг нь үнэлж Монголын урлагийн ажилтны нийгэмлэгүүдийн голбооны хорооны дарга Баартуугийн Зангадад Монгол Улсын Ардын жүжигчин цол олгосутай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

**Г. Баасансүрэнд Монгол Улсын
хөдөө аж ахуйн гавьяат меха-
никжуулагч цол олгох тухай**

Газар тариалангийн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллаж техникийн хүч чадлыг бүрэн ашиглах, эдэлгээний нормыг уртасгах, сүүлийн жилүүдэд нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, залуу механикжуулагчдыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Аргалант сумын "Нөхөрлөл" компанийн тракторч-комбайнч Гомбын Баасансүрэнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

**Б.Базарт Монгол Улсын гавьяат
тээвэрчин цол олгох тухай**

Авто тээврийн байгууллагад шатахуун тээврийн жолоочоор он удаан жил үр бүтээлтэй ажиллаж автомашин ашиглалтын эдэлгээний нормыг олон мянган километрээр давуулж, ачаа тээвэрлэлтийн тогтвортой өндөр амжилт гарган улсын дөрвөн удаагийн аварга болж, орон нутгийн тээврийн хэрэгслийн шатахууны хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монгол тээх" хувьцаат компанийн жолооч Банзрагчийн Базарт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

**Ц.Бат-Очирт Монгол Улсын
гавьяат холбоочин цол олгох
тухай**

Харилцаа холбооны байгууллагад мэргэжлийн өндөр ур чадвар гар-
ган, он удаан жил үр бүтээлтэй ажиллаж хот, хөдөө орон нутагт хол-
болтын байгууламж, холбооны шугам байгуулах, өргөтгөх, телевизийн
дахин дамжуулах станц суурилуулах зэргээр холбооны үйлчилгээний
анарын түвшинг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж
Монголын цахилгаан холбооны инженер Цэвээн-Орломын Бат-Очирт
Монгол Улсын гавьяат холбоочин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар
хот

**М. Могойтарт Монгол Улсын
гавьяат барилгачин цол
олгох тухай**

Барилгын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж орон сууц, сур-
ууль, цэцэрлэг зэрэг нийгэм ахуйн зориулалттай олон арван барилга
айгуулаамажийг орон нутагт барьж байгуулах, засварлах ажлыг
адамгай зохион байгуулж, барилгын ажилсаг бүтээлтч хамт олныг
үрдүүлэн тэдний хөдөлмөр ахуйн нөхцөлийг сайжруулах, өндөр
мэргэжлийн инженер техникийн ажилтан, ажилчинд бэлтгэх үйлсэд
руулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Булган аймгийн Барилгын
Өргөө” компанийн захирал Мятавын Могойтарт Монгол Улсын
гавьяат барилгачин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Н. Баасанжавт Монгол Улсын
хүний гавъяат эмч цол олгох
тухай

Эмнэлгийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж зүрхний олон хавч-
лагыг хиймэл хавчлагаар солих, төрөлхийн гажгийг засах, өвчтөнд
зүрхний шахилгаан идэвхжүүлэгч суулгах зэрэг нарийн төвөгтэй мэс
заслыг манай оронд анхлан хийж, оношлогоо, эмчилгээний хэд хэдэн
шинэ аргыг практикт нэвтрүүлэн өндөр мэргэжлийн эмч нарыг
бэлтгэх, мэс заслын албыг хөгжүүлэхэд оруулж байгаа гарамгай хувь
нэмрийг нь үнэлж анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн Мэс заслын
клиникийн захирал, зөвлөх эмч Начингийн Баасанжавт Монгол
Улсын хүний гавъяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1996 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Д. Нинжээд хүний гавъяат эмч
цол олгох тухай

Эрүүл мэндийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж,
мэс заслын эмчилгээний шинэ аргуудыг мэргэжлийн өндөр ур чадвар
гарган практикт нэвтрүүлж, олон мянган хүнийг мэс заслын аргаар
эмчлэн эдгэрүүлж хүн ардын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа
хувь нэмрийг нь үнэлж Клиникийн II нэгдсэн эмнэлгийн мэс заслын
их эмч Дашаахүүгийн Нинжээд Монгол Улсын хүний гавъяат эмч цол
олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ТОГТООЛ

1996 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Жагсаал, цуглаан хийх журмын тухай
Монгол Улсын хуулийн зарим заалт
Үндсэн хууль зөрчсөн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг цэцийн дарга Г. Соёл даргалж, гишүүдэд Л. Балсан, Ц. Цолмон, Н. Жанцан, Ж. Бямба, С. Жанцан /илтгэгч/, Д. Чилхаажав нар нарийн бичгийн даргаар Б. Цэндэхүүт оролцуулан хийв. Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д. Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Нямдорж нар оролцов.

Цэцийн хуралдаанаар Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн Д. Ламжавын гомдлоор үүссэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5,12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-ийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэв. Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны иргэн Д. Ламжав Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө "Жагсаал, цуглаан хийх журмын тухай" Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-ын дотор байгаа өргөдөлд дурдсан хэсэг нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26, Мөн 2-ын 1 дүгээр зүйл Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2,16 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг зөрчиж байгааг хянаж үзэхийг хүсчээ.

Үндсэн хуулийн цэц иргэн Д. Ламжавын гомдолтой маргааныг 1996 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа авч хэлэлцээд жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй "цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ", мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1-ийн 4-т буй "цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуудж явахгүй байх үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй "цуглааныг зохион байгуулагч нь ... эцгэшийн өвчтэй хүнийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ"

гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна” гэсэн 01 тоот дүгнэлт гаргажээ.

Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж хүлээн авах боломжгүй гэсэн дүгнэлтийг Улсын Их Хурлын хуралдаанд оруулжээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц. Нямдорж Улсын Их Хурлын хуралдаан дээр “хуулийн 5 дугаар зүйлд баяр ёслолын болон түүнтэй адилтгах бусад арга хэмжээнд энэ хуулийг хэрэглэхгүй гэсэн ийм заалт байгаа. Хүүхдийн зүгээс хуран цугларах аливаа ажыллага энэ заалтын хүрээнд зохион байгуулагдах боломжтой байгаа юм. Хүүхэд тайван замаар хуран цугларах асуудлыг энэ хуулиар зохицуулахад хүргэх юм бол зөвшөөрөл авах зохион байгуулагч нь үүрэг хүлээх, хариуцлага хүлээх, тэр хууль бус цуллааныг албадан тараах явцад хохирах талтай. Хүүхдийн эрхийн конвенцид хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс зарим хязгаарлалт хийж болно гэсэн заалт байдаг. Иймд хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчөөгүй байна” гэжээ.

Р. Гончигдорж “ганцхан хүүхэд гэдэг иргэнийг жагсаал цуглаанд асран хамгаалагч энэ эх, багш хүмүүстэйгээ хамт тэр жагсаал цуглаанд оролцох явдлыг бүхэлд нь хориглоно гэдэг бол үнэхээр зорилтэй гэдэг нь хэтэрхий ойлгомжтой байгаа зүйл байхгүй юу. Иймд цэцийн гаргасан дүгнэлтийг дэмжиж байна” гэжээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж “тогтоолдоо үндэслэлийг нь сайн зааж өгөхгүй бол хоёр дахиа хэлэлцэхээр ямар ч үндэслэлгүй унах ажил гардаг байхгүй юу. Дүгнэлтийг хэлэлцэж ийм учраас үндэслэлгүй гэж үзэж байгаагаа сайн тодорхой зааж өгье” гэжээ.

Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйл, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалт, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийг зорчсон байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 23 дугаар тогтоол гаргажээ.

Мөн тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот дүгнэлтийн 2 дахь заалт буюу Жагсаал цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь сэтгэцийн

өвчтэй хүнийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн хэсгийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой заалт байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанд оролцож иргэн Д. Ламжав Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5 дотор цуглааныг зохион байгуулагч бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1-ийн 4 дотор цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ гэсэн заалтууд ялж аргагүй хүүхдийн тайван замаар хуран цуглах эрхийг шууд хасаж байгаа юм гэсэн тайлбар өгчээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Намдорж Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр “Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулиар хүүхдийн хуран цуглах эрхийг хязгаарласан гэж үзэхгүй байна. Учир нь энэ хуулийн заалт нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс орсон учраас Үндсэн хууль, хүүхдийн эрхийн конвенцийн заалтуудад харшлахгүй юм” гэсэн тайлбар гаргажээ.

Хянавал:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-д буй “... цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль, тус улс албан ёсоор нэгдэн орсон хүүхдийн эрхийн тухай олон улсын Конвенцийг зөрчсөн байна. Ингэснээр хүүхдийн тайван замаар хуран цуглах эрхийг хязгаарлажээ. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн дээрх заалтуудын талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 01 тоот дүгнэлтийг хянан хэлэлцээд гаргасан Улсын Их Хурлын 1996 оны 23 дугаар тогтоолд уг дүгнэлтийг хүлээж аваагүй талаар ямар нэг үндэслэл байхгүй учир Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11, 12 дугаар зүйлийн бага насны хүүхэдтэй холбоотой заалтууд, Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолыг хүчингүй болгох нь зүйтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3,4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан “бага насны хүүхэд”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “бага насны хүүхэд бэлэн ...” гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосуйтай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

ДАРГА
ГИШУУД

Г. СОВД
Л. БААСАН
Ц. ЦОЛМОН
Н. ЖАНЦАН
Ж. БЯМБА
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 2 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

Нийгмийн халамжийн үндэсний
зөвлөл байгуулах тухай

“Нийгмийн халамжийн тухай” Монгол Улсын хуулийн 14 дүгээр үйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын дэргэд Нийгмийн аламжийн Үндэсний зөвлөл /орон тооны бус/-ийг дараахь бүрэлдэ-үүнтэйгээр байгуулж, Үндэсний зөвлөлийн дүрмийг хавсралтын соор баталсугай.

Зөвлөлийн орлогч
дарга

-Эрүүл мэндийн дэд сайд

Гишүүд:

- Дэд бүтцийн хөгжлийн яамны тээврийн газрын дарга;
- Сангийн яамны төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн газрын дарга;
- Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны нийгмийн халамжийн хэлтсийн дарга;
- Монголын ахмадын холбооны гүйцэтгэх хорооны дарга /харилцан тохиролцсоноор/;
- Монголын ҮЭ-үүдийн холбооны дэд ерөнхийлөгч /харилцан тохиролцсоноор/;
- Монголын эмэгтэйтүүдийн холбооны дэд ерөнхийлөгч /харилцан тохиролцсоноор/;
- Монголын хүүхдийн байгууллагын төв зөвлөлийн дарга /харилцан тохиролцсоноор/;
- Монголын тахир дутуу иргэдийн

нэгдсэн байгууллагын дарга
/харилцан тохиролцсоноор/.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

Э.ГОМБОЖАВ

Засгийн газрын 1996 оны 41 дү-
гээр тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ /ОРОН ТООНЫ БУС/-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл /орон тооны бус/ /шаашид "зөвлөл" гэнэ/-ийн зорилго нь нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих, нийгмийн халамжийн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, шаардлагатай асуудлаар зохих шатны байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх, нийгмийн халамж, асрамын үйлчилгээтэй холбогдуулж иргэдээс гаргасан гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахад оршино.

2. Зөвлөл нь нийгмийн халамжийн хуулиуд болон энэхүү дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

3. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд хуралдааныг зөвлөлийн тэргүүн /зөвлөлийн тэргүүний эзгүйд орлогч дарга/ удирдана. Ажлын шаардлагаар зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийж болно.

4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга /орон тооны бус/ хөтлөх ба түүнд хуралдааны дарга зөвшөөрч гарын үсэг зурна.

5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны нийгмийн халамжийн хэлтсийн дарга байна.

6. Зөвлөл нь эрхэлж буй аливаа асуудлаар санал, зөвлөлтөө авах зорилгоор хуралдаанд мэргэжлийн хүмүүсийг урьж оролцуулж болно.

7. Зөвлөлөөс хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан зөвлөмжийг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд хэрэгжүүлнэ.

8. Зөвлөл нь тэмдэг, албан бичгийн хэвтэмэл хуудас хэрэглэнэ.

9. Зөвлөлөөс үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулан нийгмийн саламжийн тухай хуулиудад заасан зөйлшгүй шаардлагатай зардлыг жил бүрийн төсвийг хянан батлах үед Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Сангийн яамнаас тогтоож өгч байна.

10. Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог нь харгалзан (өдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жишгийг баримтлан улирал тутам цалингийн нэмэгдэл элгөж болно.

Хоёр. Зөвлөлийн үүрэг, бүрэн эрх

11. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

1/нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих;

2/нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагын тайлан, мэдээллийг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар зохих шатны байгууллагад санал оруулах;

3/иргэдээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, Үйлчилгээтэй холбогдуулж гаргасан гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

4/нийгмийн халамж, хамгаалалтын асуудлаар зөвлөмж гаргах, нийгмийн халамжийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

5/нийгмийн халамжийн үйлчилгээг ивээн тэтгэх талаар байгууллага, иргэдийн санаачилга, хөдөлгөөнийг дэмжих;

6/олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийгмийн халамжийн сангаар дамжуулан хэрэгжүүлж байгаа төслийн хэрэгжилт болон уг санд оруулсан хөрөнгийн зарцуулалтын байдалд өндлөнгийн хяналт тавих.

12. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн хуваарилалт, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олголтын байдалд хяналт ивэж, шаардлагатай бол улсын төвлөрсөн төсвөөс нийгмийн халамжийн нэг төрлийн санд олгосон хөрөнгийн зарцуулагдаагүй цэвдлийг нөгөө санд шилжүүлэн зарцуулах талаар холбогдох

байгууллагатай зөвшилцөх;

2/нийгмийн халамжийн сангийн хагас жилийн болон жилийн эцсийн тайлан тэнцлийг хянан хэлэлцэж дүгнэлт гаргах;

3/амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг өөрчлөх индексийн талаар санал боловсруулах;

4/орон нутгийн төрийн захиргааны болон нийгмийн даатгалын байгууллагуудаас нийгмийн халамжийн хуулиудыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцаж, илэрсэн дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж гаргаж хэрэгжилтэд нь хяналт тавих;

5/нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээтэй холбогдсон журам, зааврын төсөлд санал өгөх, нийгмийн халамжийн салбар зөвлөлийн дүрмийг баталж мөрдүүлэх, нярай хүүхдийн арилгааны тэтгэмжийн хэмжээг тогтоох;

6/нийгмийн халамжийн талаархи мэдээ, тайлан, судалгааг холбогдох байгууллагаас гаргуулан авах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

Санхүүгийн улсын хяналт шалгалтын
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:
“Санхүүгийн улсын хяналт шалгалтын дүрэм”-ийг хавсралтын
ёсоор баталсуутай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Сангийн сайд

Э.БЯМБАЖАВ

Засгийн газрын 1996 оны 46 дугаар
тогтоолын хавсралт

САНХҮҮГИЙН УЛСЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Санхүүгийн улсын хяналт шалгалтын зорилт нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай зориулалтын сангийн бүрдүүлт, зарцуулалт, Засгийн газрын шугамаар авсан зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт болон төсвийн санхүүжилт авдаг байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийн байдлыг үндсэн баримтаар нь шалгаж үнэлэлт, дүгнэлт гарган илэрсэн зөрчил дутагдлыг эрилгуулахад оршино.

2. Санхүүгийн улсын хяналт шалгалтыг Сангийн яам, түүний санхүүгийн хяналт шалгалтын алба, яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцийн газар /төсвийн төвлөрүүлэн захирагчид/, аймаг, нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчид гэрэгжүүлнэ.

3. Санхүүгийн хяналт шалгалтын албаны дарга нь санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагч байна. Улсын ерөнхий байцаагчийг Сангийн сайд томилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4. Санхүүгийн хяналт шалгалтын улсын албаны улсын байцаагчийг ерөнхий байцаагчийн санал болгосноор Сангийн сайд, яам, засгийн газрын үндсэн болон дэд бүтцийн газарт ажиллах санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийг тухайн сайд, дарга, аймаг, нийслэлд ажиллах санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийг Засаг дарга тус тус томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээрт улсын байцаагчийн эрхийг Сангийн сайд олгоно.

5. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилт эзэмшиж, эзэмшсэн мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн байна.

6. Санхүүгийн хяналт шалгалтын улсын алба, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчид үйл ажиллагаандаа Монгол Улсын салбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү эрхийг удирдлага болгоно.

7. Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагч /шашид энэ дүрэмд "улсын байцаагч" гэж/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн

дугаар бүхий тэмдэг болон торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8. Яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцийн газар, аймаг, нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байшаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар, хангах, тэдгээрийн ажлыг шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүдэх ажлыг Сангийн яамны санхүүгийн хяналт шалгалтын улсын алба хариуцан хэрэгжүүлнэ.

9. Санхүүгийн хяналт шалгалтын алба нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт болон төсвийн санхүүжилт авдаг байгуудлагаас бусад аж ахуйн нэгж, байгуудлагад өөрсдийнх нь хүсэлт захиалгын дагуу шалгалтыг талбөртэй хийж болно. Талбөрийн хэмжээг Сангийн яамнаас тогтоосон жишгийг үндэслэн хоёр талын гэрээний үндсэн дээр харилцан тохиролцоно.

Хоёр. Санхүүгийн улсын хяналт шалгалтын чиглэл

10. Санхүүгийн хяналт шалгалтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ санхүү, төсвийн холбогдолтой хуудь тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгуудлагаас гаргасан журам, заавар, норм хэмжээний хэрэгжилт;

б/ төсвийн хөрөнгийн зарцуулалт;

в/ төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт хамгаалалт;

г/ төсвийн орлого, зарлага, төрийн өмчтэй холбоотой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт;

д/ төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, бүрдүүлэлт, төвлөрүүлэлт, татварын ногдуулалт, төлөлт, түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа, түүний биелэлт;

е/ аж ахуйн нэгж нь хуудь зүйн дагуу байгуулагдсан эсэх, үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн хүрээнд явагдаж байгаа эсэх;

ж/ тайлан тэнцэл гэргалт, тушаалтын байдал;

з/ Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандлиг, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;

и/ төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;

к/ төсвийн хөрөнгө, төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, бүртгэлтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

Гурав. Санхүүгийн хяналт шалгалтын улсын
байцаагчийн үүрэг, эрх

11. Улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

б/ хяналт шалгалтын тухай танилцуулга, бусад баримт бичгийг нэгдсэн акт, нэг бүрчилсэн акт) зохих журмын дагуу үйлдэж, хяналт шалгалт хийсэн улсын байцаагч гарын үсэг зурах;

в/ хяналт шалгалтын акт, материалыг шалгуулсан этгээдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах;

г/ хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, оо баримтын нотолгооны үнэн зөвийг хариуцах;

д/ шалгалтын дүнгээр гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт авьж, түүнийг хангуулах арга хэмжээ авах;

е/ хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн алаархи мэдээллийн нууцыг зохих хууль тогтоомжийн дагуу чанд алгалах.

12. Улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ хяналт шалгалт хийх гзар, байгууллагын үндсэн хөрөнгө, мара материал, үнэт зүйлс, мөнгөн хөрөнгөт тооллого хийлгэж, ооцоо бодуулах;

б/ шаардлагатай үед зохих байгууллагуудтай тохиролцсоны ндсэн дээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг шалгалтанд татан ролдуулах;

в/ хууль тогтоомж зөрчсөн улс, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд учруулсан хохирол, толоогүй, үндэслэлгүй тооцсон тал- өрт акт тогтоож тэлүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг эслэн зогсоох талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан ушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж, ариу авах;

г/ хяналт шалгалтын ажил шаардлагатай мэдээ, судалгаа, айлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, ж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ талбөргүй гаргуулан авах;

13. Улсын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, авьсан шаардлагыг биелүүлдэггүй гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Төснийн ухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Валютын зохицуулалтын ухай, Банкны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль огтоомжийн заалтыг үндэслэн дор дурдсан захиргааны хариуцлага үлээлгэнэ:

а/ төсвийн хөрөнгийг зээл буку гэрээний үүргийн баталгаа

болгох, бусдад хандицах, илээн тэтгэх, хувь нийлүүлэх, түр ашиг дуулах болон Засгийн газраас тогтоосон журамд зааснаас бусад хэлбэрээр эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах зэргээр төсвийн хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3000-30000 төгрөгөөр торгох;

б/ төсвийг түүний зүйлийн хооронд шилжүүлэн зарцуулахда төсвийн бусад зүйлээс цалинд, мөн Засгийн газрын тусгай зориулалтын санг өөр зүйлд шилжүүлэн зарцуулах зэргээр төсвийн хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3000-30000 төгрөгөөр торгох;

в/ бүрдүүлбэр дутуу төлбөр тооцооны баримтаар гүйлгээ хийсэн болон төлбөр тооцооны баримтыг дарагдуулсан буюу гүйлгээ саатуулсан бол банкны байгууллагын ажилтан, албан тушаалтны 10000-50000, банкны байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

г/ анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохиох ёсоо хөтлөөгүй, тайлан тэнцэл гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан, баримт материалыг бүрдүүлээгүй, эсхүл нуун дарагдуулсан албан тушаалтныг 30000-60000, иргэнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

д/ улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч хяналт шалгалтаа мэдлэхийлсэн албан тушаалтныг 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөө зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

е/ ажил олгогч шимтгэл хөдөлмөрийн хэлсний сач, түүнтэ адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатай бууруулса орлогод ногдох шимтгэлийг нөхөн төлүүлж, зөрчил гаргасан ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000, иргэнийг 30000-50000 төгрөгөөр торгох;

ж/ хуурамч бичиг баримт бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээ тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгог авсан болон үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмж төлбөрийг нөхөн төлүүлж 25000-50000 төгрөгөөр торгох;

з/ татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулса бол нуусан буюу бууруулсан орлоготой тэнцэх хэмжээний торгуул ногдуулах;

и/ орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу түүний тоо, хэмжээг санаатайгаар бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгуул ногдуулах;

к/ татвар ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, саатуулсан хоног тутамд нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувийн хүү ногдуулах /хүүгийн хэмжээ нь төлбөл зохих татварын 50 хувиас хэтэр болохгүй/;

д/ татварыг хутагтаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын үүнгээс бодож хоног тутам 0,3 хувийн хүү ногдуулах;

м/ банкны салбарыг зөвшөөрөлгүй нээсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж 150000 хүртэл төгрөгөөр торгох;

н/ банкны бус байгууллага монгол банкны зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж 50000 хүртэл төгрөгөөр торгох;

о/ талбөр тооцооны баримтыг дарагдуулсан буюу гүйлгээг аятуулсан банкны байгууллагын ажилтан, албан тушаалтныг 10000-0000 төгрөгөөр торгох;

п/ Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр гадаадаас валютын зээл авсан төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, гадаадаас авсан зээлээ Монгол банкнд бүртгүүлээгүй бусад аж ахуйн нэгж, байгууллагыг тус тус 100000 хүртэл төгрөгөөр, иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох;

р/ гадаадад хөрөнгө байршуулах, зээл тусламж олгохдоо Сангийн яаманд бүртгүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-50000 төгрөг, иргэнийг 500-50000 төгрөгөөр торгох;

с/ гадаад валютаар бэлнээр буюу бэлэн бус төлбөрийн хэрэгсэлээр авсан орлогоо Монгол банкнаас эрх олгосон арилжааны банкнд уг орлогыг авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор худалдах уяаг хадгалуулаагүй байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-100000 өгрөгөөр торгох;

т/ гадаад валют худалдах, худалдан авах болон зээлдэх, шилжүүлэх ажиллагааг, Монгол банк, түүнээс эрх олгосон арилжааны банкаар дамжуулан гүйцэтгээгүй аж ахуйн нэгж, байгууллагыг 0000-100000 төгрөг, иргэнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

у/ Монгол банкны зөвшөөрөлгүйгээр буюу олгосон зөвшөөрлийн хүрээнтээс гадуур валютын гүйлгээний үйл ажиллагаа явуулсан арилжааны банкны хууль бусаар олсон орлогыг хурааж, 50000-50000 төгрөгөөр торгох;

х/ төсвийн шууд захирагчийн тухайн жилийн төсөвт тусгасан эгз хэмжээ бүрэн хэрэгжээгүй, эсхүл норм, норматив, үнэ тарифт өргөлт орсноос хэмнэгдсэн төсвийн хөрөнгийг хураан авч арилцагч төсөвт оруулах, төсвийн хууль тогтоомж зөрсөн төсвийн мэдлүүдэн захирагч болон шууд захирагчийн данснаас зарлагын илгээ хийхийг түр зогсоох асуудлыг төсвийн ерөнхий захирагчид илж шийдвэртүүлэх;

ц/ хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан хаагчдыг эсэргүүцсэн, тогтоосон хутагтаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-5000, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах

дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэл төгрөгөөр, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр тус тус торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэртүүлэх.

14. Энэ дүрмийн 13 дугаар зүйлийн "п", "р", "с", "т", "у"-д заасан торгууль, шийтгэврийг зөвхөн Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын шийдвэрээр валютын улсын байцаагчийн эрх олгосон санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

15. Санхүүгийн улсын хяналт шалгалтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, холбогдох иргэд тогтоосон хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

16. Шалгуулсан этгээд шалгалтын баримт бичигт заасан зүйлийг зөвшөөрөөгүй бол энэ тухай тайлбараа бичиж гарын үсэг зурна.

17. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан улсын байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид тавьж болно.

Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

18. Улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлдэггүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу харнууллага хүлээлтэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 3 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөл-

мөнийг бүртгэх, мэдээлэх нийтлэг журам"-ыг хавсралтын ёсоор гаталж, энэ оны 4 дүгээр сарын 1-нээс мөрдсүгэй.

2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/энэ тогтоолоор батлагдсан нийтлэг журам хийгээд холбогч хууль тогтоомжид нийцүүлэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг нарийвчлан бүртгэх, мэдээлэх журмыг энэ оны 3 дугаар сард багтаан боловруулж мөрдсүгэй;

б/засаг захиргаа завсардсан иргэдийг энэ оны 2-3 дугаар улиралд багтаан иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэлд оруулах арга хэмжээ авсугай.

3.Хүн амын шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэлийн улсын ёлан мэдээний маягтыг шинэчилж, энэ оны 2 дугаар улирлаас лэн мөрдүүлэхийг Улсын статистикийн газар /Б.ЦЭНД-АЮУШ/, эгдээгийн ерөнхий газар /Б.ПҮРЭВ/-г даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Хүн амын бодлого,хөдөлмөрийн сайд

Э.ГОМБОЖАВ

Засгийн газрын 1996 оны 47 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ИРГЭД ШИЛЖИН СУУРЬШИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.Монгол Улсын иргэд засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэхэд энэхүү журмыг рдонө.

2.Иргэд байнга оршин сууж байсан засаг захиргааны нэг нэгжээс төнд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших /иалагд "шилжин суурьших" гэнэ/, 180 хоног ба нээс доош хугацаагаар шилжин суухыг түр шилжих гэнэ. Бүх гны сургууль, дамжанд суралцах, эмчлүүж сувилуулахаар лжигчид хугацаа харгалзахгүйгээр түр шилжсэнд тооцогдоно.

3.Иргэдийн аймагас аймагт, аймагас нийслэлд, нийслэлээс ээгт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээ-

лэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зохицуулна.

4. Иргэдийн аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьши хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар зохицуулна.

5. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнг оршин суугаа харьяалалгүй хүмүүст нэгэн адил хамаарна.

Хоёр. Иргэдийн шилжин суурьших тухай хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

6. Аймагас аймагт, аймагас нийслэлд, нийслэлтээс аймагт шилжин суурьшихыг хүссэн иргэд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, аймаг, нийслэлийн дотор шилжин суурьшихыг хүссэн иргэд сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт байнга оршин суу байгаа баг, хороогоороо уламжлан өргөдөл гаргана.

7. Өргөдөлдөө овог, нэр, ам бүлийн байдал, өөрийнхөө болон гз бүлийнхээ гишүүдийн эрхэлж байгаа ажил, мэргэжил, шилжж болсон шалтгаан, шилжээд хаана, ямар байгууллагад ажил эрхлж аль сум, дүүрэг, баг, хороонд оршин суух, амьдрах орон суу халгийг тодорхой бичнэ.

8. Ажилд томилох тухай аж ахуйн нэгж, байгууллагын алба бичиг, асран хамгаалагч, харгалзан дэмжлэгийг тодорхойлсон зөх шатны Засаг даргын тодорхойлолт буюу шүүхийн шийдвэр, гз бүлийн баталгааны нотариатаар батлуулсан хуулбар зэргийн э тохирохыг өргөдөлд хавсаргана.

9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шилжин суурьших тухай иргэдийн хүсэлтийг "Иргэдээс төрт байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдл шийдвэртлэх тухай" Монгол Улсын хуульд заасан журмын даг шийдвэртэнэ.

10. Аймагас аймагт, аймагас нийслэлд, нийслэлтээс аймагт шилжин суурьших тухай иргэний хүсэлтийг шийдвэрлэхдээ зайлыг шаардлагатай бол шилжих, шилжүүлэх аймаг, нийслэл харилц зөвшилцөж болно.

Гурав. Иргэдийн шилжин суурьшихыг түр хойшлуулах

11. Иргэдийн шилжин суурьших хүсэлтийг дор дурдсан үнд дэлээр түр хойшлуулж болно:

а/шүүхийн тогтоолоор ял тэнссэн, засан хүмүүжүүлэх ажил хийж байгаа бол шийтгэлийн хугацааг дуустал;

б/гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уул хэргийг шийдвэрлэгдэл;

в/гэр бүлээ шуцлуулах өргөмөл өгсөн бол энэ тухай шүүхийн шийдвэр гартал;

г/ажиллаж байсан байгууллагадаа өр төлбөртэй бол түүнийг барагдуултал;

д/аеран хамгаалагч, харгалзан дэмжигчээ орхиж буй бол түүнийг хэрхэхийг шийдэгдэл;

с/иргэний баримт бичгийн зөрчилтэй бол түүнийг арилгатаг;

ж/хуульд заасан бусад үндэслэл.

12.Аймаг, нийслэл нь шилжин ирж байгаа иргэнд газар олгох, ажлын байраар хангах, нийгэм, ахуйн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй бол энэ тухай мэдэгдэж, шилжүүлэн авахаас тодорхой хугацаагаар татгалзаж болно.

Дөрөв.Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх

13.Иргэдийн аймаг, нийслэлийн дотор түр шилжин суурьших хөдөлгөөнийг тэдний хувийн хүсэлт, иргэний паспорт, хүүхдийн төрсний гэрчилгээг үндэслэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймаг, хот дотор шилжин суурьших хөдөлгөөнийг тодорхойлолт - ХААТР-22 маягтыг үндэслэн бүртгэнэ.

14.Иргэдийн аймагаас аймагт, аймагаас нийслэлд, нийслэлээс аймагт түр шилжин суурьших хөдөлгөөнийг тэдний хувийн хүсэлт, иргэний паспорт, хүүхдийн төрсний гэрчилгээг үндэслэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймаг, хотод үрмэсөн шилжин суурьших хөдөлгөөнийг тодорхойлолт-ХААТР-24, аймаг, нийслэлд үрмэсөн шилжин ирэх хөдөлгөөнийг олоорхойлолт- ХААТР-23 маягтаар тус тус бүртгэнэ.

15.Түр шилжин суугчдын хөдөлгөөнийг дор дурдсан журмаар үртгэнэ:

а/иргэдийн 30 хоногоос дээш хугацаагаар түр шилжин суурьших тохиолдолд байнга оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ бүртгэлд түр эзгүй" гэсэн тэмдэглэл хийлгэж, түр оршин сууж байгаа нутаг дэвсгэртээ долоо хоногийн дотор бүртгүүлж "түр суугч" гэсэн эмдэглэл хийлгэнэ;

Хэрэв иргэн түр оршин суух хугацаандаа байнга оршин суудаг утаг дэвсгэртээ хүндэтгэх шалтгаанаар буцаж чадахгүйд хүрвэл түр оршин суух зөвшөөрлөө сунгуулж болно.

б/өөр аймаг, сумаас бүх шатны сургуульд суралцагчдыг сум, хороодын Засаг даргын Тамгын газар оршин суугаа хаягаар нь тусгайлан бүртгэж байна.

16.Шилжин суурьших хөдөлгөөнийг дор дурдсан журмаар мэдээлж байна:

а/шилжин ирэгсэд, явагсдын бүртгэлийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар эрхлэн хөгөлж, сумын Засаг даргын Тамгын газар сар бүрийн мэдээг дараа сарын эхний 10 хоногийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт, аймгийн Засаг даргын Тамгын газар түүнийг мөн сарын эхний 15 хоногийн дотор Цагдаагийн ерөнхий газрын Иргэний бүртгэл, мэдээллийн төвд мэдээлнэ.

Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар сар бүрийн мэдээг дараа сарын эхний 10 хоногийн дотор Иргэний бүртгэл, мэдээллийн төвд мэдээлнэ;

б/Иргэний бүртгэл, мэдээллийн төв шилжин суурьших хөдөлгөөний мэдээг хагас жил тутамд нэгтгэн Улсын статистикийн газарт гарган өгч байна.

Тав.Хүлээлгэх хариуцлага

17.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтанд сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн эрх бүхий ажилтнууд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л.Цог
Нарийн бичгийн дарга	Сав. Жаргалсайхан
Гишүүд	Т. Баасансүрэн
	Ч. Бавуу
	Б. Ганбат
	Б. Янжигсалхам

Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сав. Жаргалсайхан
	Б. Янжигсалхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 7-р сарын 28-нд
Өрөлтөд 1996 оны 8-р сарын 5-нд Хэвлэлтэд
1996 оны 8-р сарын 19-нд Хэвлэлийн хуудас 5,0
Хэвлэсэн тоо 4200

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг
эрхлэх газрын харьяа
хэвлэх үйлдвэр